



БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ЯАМ



“Байгаль хамгаалагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн хамгааллын талаар санал авах” ТӨСЛИЙН ТАЙЛАН

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр
“Монголын унаган байгалийн хүлцэл, тогтворжилтыг хангах нь”
төсөл
“Монголын байгаль хамгаалагчдын холбоо” ТББ

2022 он

Contents

1. Удиртгал	3
1.1 Төслийн зорилт, хүлээгдэж буй үр дүн, хэрэгжүүлэх арга хэмжээ	3
1.2. Гэрээт ажлын зорилт, хамрах хүрээ, хүлээгдэж буй үр дүн	4
2. Хэрэгжүүлэгчид, санхүүжилт	5
2.1. Хэрэгжүүлэгчид	5
2.2. Санхүүжилт	6
3. Арга зүй, судалгаанд хамрагдсан байгаль хамгаалагчдын мэдээлэл	6
3.1 Арга зүй	6
3.1 Судалгаанд хамрагдсан байгаль хамгаалагчдын мэдээлэл	7
4. Байгаль хамгаалагчдын сургалтад хамрагдсан байдал ба үр өгөөж	7
4.1. Байгаль хамгаалагчдын сургалтад хамрагдсан байдал.....	7
4.2 Зөвлөмж	9
5. Байгаль хамгаалагчдын ажлын байрны нөхцөл, эрсдэл	10
5.1. Байгаль хамгаалагчийн байршил.....	10
5.2. Ажлын байрны нөхцөл	11
5.3. Ажлын байрны дарамт, байгаль хамгаалагчдын аюулгүй байдлыг хамгаалах асуудал	11
5.4. Байгаль хамгаалагчдын ажилтай нь уялдсан халдлага, эрсдэл, тэднийг хамгаалах тогтолцоо	12
5.5. Байгаль хамгаалагчдын ажиллах нөхцөл, сэтгэл зүйн байдал.....	13
6. Байгаль хамгаалагчдын нийгмийн баталгаа	14
6.1. Цалин орлого, хангамж, статус.....	14
6.2. Зөвлөмж	16
7. Хавсралтууд	17
VII.1 Аман судалгааны асуулга	17
VII.2. Судалгаанд хамрагдсан байгаль хамгаалагчдын мэдээлэл.....	23
VII.3. Байгаль хамгаалагчдын сургалтын үр нөлөө ба хэрэгцээ.....	24
VII.4. Байгаль хамгаалагчдын ажлын байрны нөхцөл, эрсдэл	25
VII.5. Байгаль хамгаалагчдын ажилтай нь уялдсан халдлага, эрсдэл, тэднийг хамгаалах тогтолцоо	26
VII.6. Байгаль хамгаалагчдын ажиллах нөхцөл, сэтгэл зүйн байдал	27
VII.7. Байгаль хамгаалагчдын нийгмийн баталгаа	28
VII.8. TERMS OF REFERENCE	31
VII.9. Байгаль хамгаалагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр ...	38
VII.10. Байгаль хамгаалагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр	48

1. Удиртгал

1.1 Төслийн зорилт, хүлээгдэж буй үр дүн, хэрэгжүүлэх арга хэмжээ

“Монголын унаган байгалийн хүлцэл, тогтворжилтыг хангах нь” төслийн баримт бичигт Монголын байгаль орчныг доройтуулж буй гол аюул, заналаар бэлчээрийн талхигдал, хууль бус агнуур, ойн хууль бус ашиглалт, ойн түймэр, хортон шаьжийн хөнөөл, уул уурхай болон дэд бүтцийн хөгжлөөс голлон шалтгаалж байна гэж тогтоосон байна.

Төслийн хэрэгжилтийн явцад олж авсан сургамж, гарсан үр дүнг төсөл хэрэгжиж буй аймгуудын нийт нутаг дэвсгэр улмаар нийт Монгол орны хэмжээнд түгээн дэлгэрүүлснээр дээр дурьдсан Монголын байгаль орчинд учирч буй гол аюул заналыг арилгах боломжтой гэж үзсэн байна.

Төслийн баримт бичигт тодохойлсноор Монголын байгаль орчны өмнө тулгарч буй аюул заналыг амжилттай шийдвэрлэхэд дараах нийтлэг бэрхшээл тулгарч байна гэж үзжээ, үүнд:

- Орон нутгийн түвшинд ногоон хөгжлийн үзэл баримтлалыг амжилттай хэрэгжүүлэх бодлого, эрхзүйн орчин, арга хэрэгсэл, чадавхи дутмаг
- Ландшафтын түвшинд бэлчээр, ойн тогтвортой менежмент, биологийн олон янз байдлыг хамгаалах талаарх сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, нэвтрүүлэхэд орон нутгийн холбогдох талуудын мэдлэг, чадавхи хангалтгүй
- Орон нутгийн түвшинд иргэдийн амьжиргааг дээшлүүлэх, биологийн олон янз байдлын хамгаалах, бэлчээр, ойн тогтвортой менежментийг бий болгоход чиглэгдсэн үйл ажиллагааны харилцан уялдаа сул
- Мэдлэгийн менежмент, ногоон хөгжлийн үзэл баримтлалын хэрэгжилтийг хянах хяналт-үнэлгээний тогтолцоо сул

Дээрх бэрхшээлүүдийг шийдвэрлэх аливаа үйл ажиллагаа нь сумдын болон улсын тусгай хамгаалалттай газруудын байгаль хамгаалагчдын идэвхтэй оролцооноос ихээхэн хамаарна.

Монголын байгаль хамгаалагчид албан үүргээ гүйцэтгэх явцдаа амь нас, эрүүл мэнд, сэтгэл санааны дарамтад орж хохирох тохиолдлууд удаа дараа гарах боллоо. Иймээс байгаль хамгаалагчдын ажлын байр нь эрсдэл ихтэй гэж үнэлэгдэх болж байна. Түүнээс гадна байгаль хамгаалагчдын цалин орлого нь бусад төрийн байгууллагын ажилтнуудтай харьцуулахад бага байдаг, байгаль орчны асуудлыг шийдэх шаардлагаар хөдөө их ажилладаг боловч албаны хэрэгцээний унаа байдаггүйгээс өөрсдийн унаагаар явдаг, хээрийн нэмэгдэлгүй атлаа хөдөө ажиллах нь их гэх мэт олон асуудлыг шийдэх хэрэгцээ тулгарч байна.

Үүний тулд “Монголын байгаль хамгаалагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр” боловсруулах замаар дээрх асуудлыг цогцоор нь шийдвэрлэх хэрэгтэй байв.

Дээрх асуудлыг шийдэхэд үнэн бодитой мэдээлэл хэрэгтэй бөгөөд ийм мэдээлэл хангалтгүй байгаа ба санхүүгийн хүрэлцээ хангалтгүйгээс бүх байгаль

хамгаалагчдыг хамруулсан судалгааг газар дээр нь очиж авах боломж байхгүй байна.

Харин ENSURE төсөл хамрагддаг нутгийнхаа байгаль хамгаалагчдыг хамруулсан судалгааг хийхэд дэмжлэг үзүүлснээр энэхүү төслийг хэрэгжүүлэв.

ENSURE төслийн хамрах сумдын нутаг дахь сумдын болон, улсын тусгай хамгаалалттай газруудын байгаль хамгаалагчдаас судалгаа авч үнэлэт дүнэлт өгөх, холбогдох санал гаргах зорилгоор энэхүү зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэв.

Энэхүү судалгааны үр дүн нь цөөн аймаг, сумдыг хамарсан боловч улсын хэмжээний байгаль хамгаалагчдын сургалтад хамрагдсан байдал, ажлын байрны нөхцөл, нийгмийн баталгаатай холбоотой төлөв байдлыг үндсэнд нь илэрхийлж чадна үзлээ.

Судалгааг “Монголын байгаль хамгаалагчдын холбоо” (МБХХ) ТББ өөрсдийн гишүүдийн хүчээр зохион байгуулна.

МБХХ_нь 2016 онд санаачлагдан, 2018 онд албан ёсоор улсын бүртгэлд бүртгэгдсэн, байгаль хамгаалагчдын эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаагаа явуулдаг төрийн бус байгууллага юм.

1.2. Гэрээт ажлын зорилт, хамрах хүрээ, хүлээгдэж буй үр дүн

Энэхүү гэрээт ажил нь:

- Төслийн зорилтот бүсэд сумын байгаль хамгаалагч, тусгай хамгаалалттай газрын байгаль хамгаалагч, байгаль орчны улсын байцаагчийн зэрэгтэй байгаль хамгаалагч, сайн дурын байгаль хамгаалагчийн өнөөгийн байдалд үнэлгээ хийх;

- Үнэлгээнд үндэслэн байгаль хамгаалагчдын тодорхой хяналт шалгалт, үүргийн бодит эрэлт/хэрэгцээг тодорхойлж, зохицуулалт, менежментийг сайжруулах тодорхой шийдлүүдийг санал болгоно. Ялангуяа тэдний ажлын байранд тавигдах шаардлага, холбогдох хууль тогтоомж, хүний нөөцийн чадавхитай холбоотой асуудалд дүн шинжилгээ хийж, зөвлөмж боловсруулах.

- Улсын хэмжээнд хэрэг болохуйц бүх байгаль хамгаалагчдын ажиллах нөхцөлийг үнэлэх загвар боловсруулах зорилготой.

Энэ зорилгоо хэрэгжүүлэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлсэн.

Зорилт-1. Байгаль хамгаалагчдын салбарт эрх зүйн орчин, эрх, үүрэг, ажлын нөхцөл, цалин нийгмийн хамгаалалд дүн шинжилгээ хийх, дутагдлыг тодорхойлно

Зорилт-2. 13 сумын байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагчдаас ярилцлага, асуулгын аргаар мэдээлэл авах;

Зорилт-3. Цуглуулсан мэдээллийг боловсруулах;

Зорилт-4. Зөвлөмж, шийдэл, хууль эрх зүйн орчны санал, байгаль хамгаалагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн хамгааллын хөтөлбөрийн санал боловсруулах.

Зорилго-5. Үр дүнг талуудтай ярилцаж, холбогдох байгууллагуудад танилцуулах.

Хамрах хүрээ нь:

1. Говь-Алтай аймгийн Эрдэнэ, Цогт (Зармангийн говь), Чандмань (Улаан шал) сум,
2. Баянхонгор аймгийн Баян-Өндөр, Шинэжинст (Зармангийн говь), Баянцагаан, Баацагаан (Улаан шал)
3. Архангай аймгийн Батцэнгэл, Өлзийт, Хайрхан, Эрдэнэцогт (Бөхөн шар)
4. Завхан аймгийн Тосонцэнгэл, Их-Уул (Тарвагатай) сумдын болон эдгээр сумдын нутагт байрладаг УТХГ-ын байгаль хамгаалагчид хамаарна.

Боломжтой үедээ бусад аймгуудын нутагт зарим байгаль хамгаалагчдаас мөн санал асуулгын хуудсаар мэдээлэл цуглуулсан болно. Тухайлбал, Увс нуурын ай савын улсын ТХГ-ын байгаль хамгаалагчид, Говийн их ДЦГ-ын байгаль хамгаалагчид энэ судалгаанд оролцсон болно.

Байгаль хамгаалах бодлогыг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих үүргийн анхан шатны нэгжид оногдох ачаалал нь байгаль хамгаалагчид оногддог бөгөөд байгаль хамгаалагчид нь хир зэрэг чадавхижсан, ажиллах нөхцлөөр болон нийгмийн баталгаагаар хангагдсанаас үр дүн шалтгаална.

Эрх зүйн холбогдолтой саналаа тайланд хавсаргасныг холбогдох газруудад уламжилж батлуулах шаардлагатай.

Үүний тулд холбогдох эрхзүйн орчинд үнэлгээ хийх шаардлага бий.

2. Хэрэгжүүлэгчид, санхүүжилт

2.1. Хэрэгжүүлэгчид

1. С.Амгаланбаатар, - МБХХ-ны тэргүүн, (Завханы Тосон цэнгэл, Их-Уул),
2. О.Амарзаяа, - (Архангайн Батцэнгэл, Өлзийт, Хайрхан, Эрдэнэмандал),
3. Г.Энхтүвшин, - МБХХ-ны УЗ-ийн гишүүн, (Говь-Алтайн Эрдэнэ, Цогт, Чандмань),
4. Б.Баярмаа, - МБХХ-ны гишүүн, (Баянхонгорын Баянцагаан, Баацагаан, Баян-Өндөр, Шинэжинст),
5. Ц.Дэлгэрмэнд - МБХХ-ны гишүүн, социологч,
6. Г.Дашдэмбэрэл - МБХХ-ны удирдах зөвлөлийн гишүүн, хуульч

2.2. Санхүүжилт

Байгаль хамгаалагчдын сургалт, ажлын байрны нөхцөл, нийгмийн баталгааг хангах үйл ажиллагааг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмын дагуу хэрэгжүүлэх нь зүйтэй бөгөөд гол нь санхүүжилтийг шийдсэн байх ёстой.

Санхүүжилт нь **“Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай”** хуулийн хүрээнд шийдэх боломжтой.

Тусгай хамгаалалттай газруудын байгаль хамгаалагчдад шаардлагатай санхүүжилтийг улсын төсвөөс, сумын байгаль хамгаалагчдад шаардлагатай зардлыг тухайн аймаг, сумын Засаг дарга дээрх хуулийн хүрээнд төсөвлөн шийдвэрлэх бүрэн боломжтой.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ыг баталсан бөгөөд энэ журмын 2.2-т Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нар тухайн жилийн төсвийн суурь зарлагын төлөвлөгөөнд дараах арга арга хэмжээг төлөвлөж ИТХ-аараа батлуулах үүрэг хүлээсэн байдаг.

Уг журмаар аймаг нийслэлийн Засаг дарга нь тухайн жил хэрэгжүүлэх байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөө, шалгуур үзүүлэлт, зарцуулах төсвийг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хийх гэрээнд тусгахаар зохицуулсан байдаг тул БОАЖ-ын сайд нь аймгийн Засаг дарга нартай хийх гэрээндээ тодорхой тусгах хэрэгтэй юм.

3. Арга зүй, судалгаанд хамрагдсан байгаль хамгаалагчдын мэдээлэл

3.1 Арга зүй

Монголын байгаль хамгаалагчдын сургалтын хэрэгцээ, ажлын байрны нөхцөл, нийгмийн баталгааны талаарх нөхцлийг байгаль хамгаалагчдаас өөрсдөөр нь үнэлүүлэх, улмаар “Байгаль хамгаалагчдын сургалт, ажлын байрны нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр” боловсруулахад үндэслэл болгон ашиглах суурь мэдээллийг бий болгох зорилготой.

Судалгааг нийтдээ 75 асуулт бүхий санал асуулгын хуудас бэлтгэн мэдээлэл цуглуулсан. (Асуулгыг хасваргав)

МБХХ ба ENSURE төслийн хооронд 2022-04-26-ны өдөр гэрээ байгуулсан.

2022 оны 7-р сарын 25-аас 9-р сарын 25 хүртэл мэдээлэл цуглуулахаар орон нутагт ажилласан. Эхний санхүүжилтийг 8-р сарын 22-нд авсан. 2022-10-р сарын 1-ээс мэдээлэл боловсруулалтад ажилласан.

3.1 Судалгаанд хамрагдсан байгаль хамгаалагчдын мэдээлэл

Судалгаанд зорилтот сумдын байгаль хамгаалагчдыг бүрэн хамруулах зорилт тавьсан.

Баянхонгор аймгаас 7, Говь-Алтай аймгаас 11, Архангай аймгаас 10, Завхан аймгаас 18 байгаль хамгаалагчаас мэдээлэл авснаас гадна нэмэлтээр Увс аймгаас 14, говийн бусад аймгаас 8, нийт 68 байгаль хамгаалагчаас мэдээлэл авсан байна. Үүнээс УТХГ-ын 37 байгаль хамгаалагч хамгаалагчаас мэдээлэл авсан. Үүнд, Баянхонгор аймгаас 1, Говь-Алтай аймгаас 8, Архангай аймгаас 2, Завхан аймгаас 12 байгаль хамгаалагчаас мэдээлэл авснаас гадна Увс аймгаас 14 байгаль хамгаалагч, БОХУБ-аас мэдээлэл авсан.

Сумын 21 байгаль хамгаалагчаас мэдээлэл авснаас Баянхонгор аймгаас 6, Говь-Алтай аймгаас 3, Архангай аймгаас 6, Завхан аймгаас 6 байгаль хамгаалагчаас мэдээлэл авчээ.

Судалгаанд хамрагдсан байгаль хамгаалагчдын 13.24% нь эмэгтэй, 86.76% нь эрэгтэй байв.

Судалгаанд оролцогсдын 32.37% нь сумын байгаль хамгаалагч, 55.85% нь УТХГ-ын байгаль хамгаалагч, 7.39% нь БОХУБ, 1.5% нь идэвхтэн байгаль хамгаалагч, 2.9% нь байгаль хамгаалах үүрэгтэй албан тушаалтан (ТХГ-ын мэргэжилтэн) байв.

Судалгаанд хамрагдсан байгаль хамгаалагчдын 21.3% нь БОХУБ эрхтэй байгаль хамгаалагч байлаа.

Судалгаанд хамрагдагсдын 58.9% нь бакалавр, 2.9% нь магистр зэрэгтэй байв (Хавсралт V.2).

4. Байгаль хамгаалагчдын сургалтад хамрагдсан байдал ба үр өгөөж

4.1. Байгаль хамгаалагчдын сургалтад хамрагдсан байдал

Байгаль хамгаалагчид мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэхтэй холбоотой сургалтуудад голлон ажилласан жилээсээ хамаарч харилцан адилгүй хамрагдсан байна. Гэвч төрөлжсөн сургалт бүрд бүрэн хамрагдаж чаддаггүй байна. Судалгаанд хамрагдсан байгаль хамгаалагчдын 60.4% нь 1-10 удаа, 8.8% нь 11-20 удаа, 4.4% нь 21-ээс дээш удаа сургалтад хамоагдаж байсан ба 7.3% нь сургалтад хамрагдаж байгаагүй бол 19.1% нь энэ талаар хариулж чадаагүй байна. Сургалтад хамрагдсан байгаль хамгаалагчдын сэтгэл ханамжийн байдал өөр өөр байна. Судалгаанд

хамрагдагсдын 17.6% нь сургалтууд ерөнхийдөө “маш сайн” байсан гэж үнэлсэн бол 36.8% нь “сайн”, 33.8% нь “боломжийн”, 1.5% нь “сайнгүй” гэж үнэлсэн бол 10.3% нь хариулаагүй байна.

Эндээс байгаль хамгаалагчдад зориулсан сургалт ерөнхийдөө мэргэжлийн түвшинд боловсрогдсон, чадварлаг багш нар сургалт зохион байгуулдаг, сэдэв нь турхайн үеийн хэрэгцээ шаардлагад нийцсэн байдаг гэж үнэлж болохоор байна. Гэвч сургалт бүрийн дараа сургалтын үнэлгээг хийж цаашилд хэрхэн сайжруулах зөвлөмжийг тайландаа тусгадаг, үүнийг нь БОАЖЯ-ны ТХБНУГ нэгтгэн дүгнэлт хийж дараагийн сургалтын хөтөлбөртөө тусгаж, мэдээллийн сандаа хадгалж байх хэрэгтэй юм.

Байгаль хамгаалагчдад зориулсан сургалт нь ихэвчлэн мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэхэд зориулагддаг боловч бусад чиглэлийн сургалтууд багагүй хувийг эзэлдэг байна.

Давхардсан тоогоор байгаль хамгаалагчдын 80,9% нь “мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх”, 50.0% нь “аюулгүй ажиллагааны”, 51.5% нь “тоног төхөөрөмж ашиглах зааварчилгаа”, 27.9% нь “хувийн хөгжлийн” сургалтад хамрагдсан байна.

Ер нь ч байгаль хамгаалагчид өөрсдөө мэргэжлийн ур чадвараа хөгжүүлэх сургалтуудыг илүү сонирхдог байна.

Судалгаанд хамрагдагсдын 79,4% нь “мэргэжлийн ур чадвараа хөгжүүлэх”, 55,9% нь “аюулгүй ажиллагааны”, 33,8% нь “тоног төхөөрөмж ашиглах зааварчилгаа”, 17.6% нь “хувийн хөгжлийн” сургалтад хамрагдах сонирхолтой байдаг байна (Хавсралт V.3).

“Мэргэжлийн ур чадвар” олгох сургалт нь байгалийн бүсчлэлээр ялгаатай байх шаардлагатай байна. Жишээ нь, ойт хээр, хээрийг бүсэд ажилладаг байгаль хамгаалагчдад түймрээс хамгаалах, сэргийлэх, тэмцэх талаар илүү мэдлэг олгох чадавхижуулах шаардлагатай бол говийн бүсэд төдийлөн шаардлагагүй байдаг.

Сургалтууд байгаль хамгаалагчдын ажилд хэрхэн нөлөөлдөг вэ? Сургалтын дараа ажлын чанарт нь үнэхээр ахиц гарч чадаж байна уу? Эдгээр асуултуудын үнэн зөв хариулт нь сургалтын төрөл, агуулга, хэлбэрийг сайжруулах үндэслэл болно.

Судалгаанд хамрагдагсдын 10.3% нь сургалтын дараа ажлын чанарт “маш сайн” ахиц гарсан гэж үзсэн бол 36.8% нь “сайн”, 35.3% нь “боломжийн”, 2.9% нь “сайнгүй” ахиц гарсан үзсэн ба харин 14.7% нь энэ асуултад хариулаагүй байна.

Сургалтын дараа мэдлэг эзэмшсэнийг нотлох сертификат өгч байх нь сургалтын албан ёсны болохыг илэрхийлдэг. Зарим сургалтууд нэр төдий зохион

байгуулагддаг, ямар нэгэн батламж, сертификат өгдөггүй байна. Батламж, сертификат өгдөггүй сургалтын чанарын асуудал нь тодорхойгүй үлддэг.

Судалгаанд хамрагдагсдын 66,2% нь сертификат авсан, 22,0% нь сертификат аваагүй гэсэн бол 11,8% нь мэдээлэл өгөөгүй байна.

Байгаль орчныг хамгаалах тухай” хуулийн 26.6-д “Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас байгаль орчны чиглэлээр сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий сургуулийн мэргэжлийн сургалтанд хамрагдаж төгссөн иргэнийг байгаль хамгаалагчаар ажиллуулна” гэж заасан нь бий. Монголд одоогоор байгаль орчны чиглэлээр “байгаль хамгаалагч” мэргэжил олгодог сургалт үйлдвэрлэлийн төвүүд “ойжуулагч” мэргэжил олгодог сургалтыг эс тооцвол байхгүй бөгөөд дипломын боловсрол олгодог тусгай дунд (техникум) сургуулиуд байхгүй. Иймд зөвхөн дээд сургууль төгсөж бакалавр төвшний боловсрол эзэмшиж байж байгаль орчны мэргэжил эзэмших боломжтой болно.

Судалгаанд хамрагдсан байгаль хамгаалагчдын 91,2% нь мэдлэг, боловсролоо дээшлүүлэх сонирхолтой байгаагаа илэрхийлсэн нь тэдний өөрийгөө хөгжүүлэх идэвх өндөр байгааг харуулсан үзүүлэлт юм.

Тэдний 1,7% нь “бүрэн дунд”, 18,3% нь “бакалавр”, 20,0% нь магистрын зэрэг авч боловсролоо дээшлүүлэхийг хүсдэг бол 60,0% нь төрөлжсөн сургалтуудаар боловсролоо түвшнээ биш мэдлэгээ дээшлүүлэхийг илүүд үзсэн байна. Энэ дүнгээс харахад мэргэжлийн бус, бүрэн дунд боловсролгүй хүнийг байгаль хамгаалагчаар ажилд авч хууль зөрчих нь нилээд байдаг байна (Хавсралт V.3).

Хөдөө хээрт, суурин газраас алсад, байгаль дундаа амьдардаг байгалиа хамгаалах сэтгэлтэй иргэдийг байгаль хамгаалагчаар ажиллуулах нь үр дүнтэй байх нь ойлгомжтой. Гэсэн хэдий ч ийм хүмүүс дээд боловсролгүй, мэргэжилгүй байдаг төдийгүй үнэндээ олон жилээр мал аж ахуй, гэрээсээ хол дээд сургуульд суралцах боломж бага байдаг. Иймээс цөөн 1-2 жилийн хугацаатай мэргэжил олгох дипломын сургалтуудад хамруулан “байгаль хамгаалагч” мэргэжил олгох нь зүйтэй. Энэ сургалт нь эчнээ, зайны сургалт байвал тэдэнд илүү зохимжтой байна.

4.2 Зөвлөмж

- Байгаль хамгаалагчид олон жил ажилласан ч, анх орсон байгаль хамгаалагч ч адил хөтөлбөртэй сургалтад хамрагддаг байна. Иймд олон жил ажилласан, онолын мэдлэг, ажлын туршлага харьцангуй өндөр байгаль хамгаалагчид анхныхаа сургалтад хамрагдаж буй байгаль хамгаалагчдаас илүү нарийн мэдээлэл бүхий, өндөр түвшний давтан сургалтад хамрагдах нь зүйтэй юм. Давтан сургалтад

хамрагдаган сертификат авсан байгаль хамгаалагчдын цалин хөлс, зэрэг дэв нэмэгдэж байх нь ур чадварыг ялгавартай үнэлж байгаа төдийгүй эдийн засгийн хөшүүргээр урамшуулах, нэр төрийг өргөж буй зэрэг ач холбогдолтой юм.

Иймд байгаль хамгаалагчдыг ажилласан жилийг нь харгалзан шаталсан сургалтад хамруулж байх хэрэгтэй юм.

Байгаль хамгаалагчдыг заавал дээд сургууль гэхгүй сургалт үйлдвэрлэлийн төвүүдэд (хуучнаар ТМС) “байгаль хамгаалагч” мэргэжлээр бэлтгэх асуудлыг судалж шийдвэрлэх боломжтой.

- Шаталсан сургалтад төдийгүй завсрын төрөлжсөн мэдлэг олгох сургалтад хамрагдсан оролцогчдод батламж буюу сертификат олгож байх,
- Байгаль хамгаалагчийн мэргэжил олгох сургалтыг сургалт үйлдвэрлэлийн төвүүдэд зохион байгуулж диплом олгох ажлыг шийдвэрлэх. Үүнд БСШУЯ-ны дэргэдэх Мэргэжлийн боловсрол сургалтын Мэргэжил-арга зүйн төвөөс боловсруулсан “Мэргэжлийн боловсрол сургалтын стандарт”, MNS 5370:2004”-ыг (Мэргэжлийн нэр: байгаль хамгаалагч; Индекс: BE 850100 (Дипломын)) ашиглах.
- Байгаль хамгаалагчдын мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрийг бүсчлэлийн ялгаатай боловсруулж батлуулах, хэрэгжүүлэх

5. Байгаль хамгаалагчдын ажлын байрны нөхцөл, эрсдэл

5.1. Байгаль хамгаалагчийн байршил

Байгаль хамгаалагчдын ажлын байрны нөхцөл нь тэдний хэвийн ажиллах боломжоор хангагдсан эсэхийн шалгуур болно. Ялангуяа гэрийн байршил нь яг байгаль хамгаалагчийн хуулиар хүлээсэн үүргээ гүйцэтгэхэд голлох нөхцөл болдог.

Судалгаанд хамрагдагсдын 32,8% нь хөдөө орон нутагт байдаг бол 67,2% нь сумын төвд байдаг байна.

Сумын төвд ажиллаж буй байгаль хамгаалагчид, БОХУБ-ын хувьд ажлын байр нь сумын ЗДТГ байна. Хөдөө орон нутагт амьдардаг байгаль хамгаалагч бүрт зориулж тусгайлан “ажлын байр” барих боломж хомс. Иймд байгаль хамгаалагчдын гэрийг “ажлын байр” гэж албан ёсоор хуулинд заалт оруулж хүлээн зөвшөөрөх шаардлагатай байна.

2022 онд албан ажилтай нь буюу үүрэгт ажилтай нь холбоотойгоор согтуу нөхөр байгаль хамгаалагчийг гэртээ байхад нь зодож хүнд гэмтэл учруулсан бөгөөд багагүй хугацаанд эмнэлгээр эмчлүүлж хөдөлмөрийн чадвараа алдсан бөгөөд хуулийн байгууллагаас “албан үүргээ гүйцэтгэж байхад нь буюу ажлын байранд нь бус гэрт нь зодсон тул “хууль сахиулагчид” халдсан гэх үндэслэлгүй” гэсэн утгатай тайлбар

өгч байсан мэдээлэл бий. Иймд хөдөө орон нутагт амьдардаг байгаль хамгаалагчийн гэрийг “ажлын байр” гэж үзэж хуульчлах шаардлага тулгамдан гарч байна.

5.2. Ажлын байрны нөхцөл

Сумын төвд буй байгаль хамгаалагчдын ажлын байр нь сумын ЗДТГ-т байх боловч ажиллах нөхцлөөр төдийлөн сайн хангагдаж чадаагүй байдаг байна. Оффисийн хэрэглэхүүн, тухайлбал компьютер, принтер, сандал ширээнээс эхлээд тусгайлан эзэмшүүлсэн техник хэрэгсэл зарим газарт байхгүй, ихэвчлэн дундаа хэрэглэдэг байна.

Судалгаанд хамрагдагсдын 70,6% нь ажлын байр “тохиромжтой”, 23,5% нь “тохиромжгүй” гэж үзсэн бол 5,9% нь юу гэж хариулахаа “мэдэхгүй” гэсэн байна.

Үүрэгт ажилтайгаа холбоотой техник болон бие хамгаалах хэрэгслэлийн хувьд 47,1% нь мотоциклоор, 72,1% нь дурангаар, 4,4% нь зургийн аппаратаар, 4.4% нь богино долгионы станцаар хангагдсан байна. Баримтжуулах, ажиглах, харилцаа холбооны хэрэгслэл зэрэг нэн шаардлагатай багаж хэрэгслэлээр байгаль хамгаалагчид маш муу хангагдсан байна. УТХГ-ын байгаль хамгаалагчдыг сумын байгаль хамгаалагчидтай харьцуулахад арай дээр хангагдсан байна.

Байгаль хамгаалагчаар ажиллахад орон нутагт мэргэжилтэй боловсон хүчний нөө муу байдаг. Иймээс байгаль хамгаалагчид “Байгаль хамгаалагчийн ажлын байрны тодорхойлолтод дурдсан боловсрол, мэдлэгийн шаардлага нь бодит байдалд нийцэлтэй эсэх”-эд 57,3% нь “нийцэлтэй” гэж үздэг бол 30,9% нь “”үгүй” гэж, харин 11,8% нь “мэдэхгүй” гэж хариулсан байна (Хавсралт V.4).

Судалгаанаас үзэхэд дээд боловсролтой гэх байгаль хамгаалагчдын дийлэнх нь хувийн “Эко-Ази” дээд сургуулийг төгссөн ба эчнээгээр цөөн цагийн сургалтад хамрагдаад дээд боловсролын диплом авсан байдаг байна.

Чанаргүй их, дээд сургуулийн дипломоос чанартай сургалт үйлдвэрлэлийн төвийн мэргэжлийн үнэмлэхийг дээр гэж үзэх байгаль хамгаалагчид байгааг анхаарах л хэрэгтэй юм.

5.3. Ажлын байрны дарамт, байгаль хамгаалагчдын аюулгүй байдлыг хамгаалах асуудал

Байгаль хамгаалагчид ажлын байрандаа, албан үүргээ гүйцэтгэж байхдаа болон энэ шалтгаанаар гэр орондоо байхдаа ч дарамтад өртөх нь цөөнгүй байна. Судалгаанд хамрагдагсдын 35,3% нь халдлага дарамтад өртөж байсан байна. Халдлага, дарамтад өртсөн байгаль хамгаалагчид энэ тооноос их байдаг бөгөөд нэр төрд нь сэв сууна гэх болгоомжлол, дараа нь улам дарамтлах байх гэсэн айдас зэргээс шалтгаалан нуух, ил мэдээлэхээс татгалзах байдал гаргадаг байна.

Байгаль хамгаалагчдын 38,2% нь “хамтран ажиллагчид нь халдлага, дарамтад өртөж байсан” талаар мэдээлснээс харахад цөөнгүй байгаль хамгаалагчид халдлагад өртөж байснаа ямар нэг дарамт, айдсаасаа болж нуудаг нь харагдаж байна (Хавсралт V.4.).

5.4. Байгаль хамгаалагчдын ажилтай нь уялдсан халдлага, эрсдэл, тэднийг хамгаалах тогтолцоо

Халдлага дарамтад өртөөгүй ч байгаль хамгаалагчдын 69,2% нь “халдлага дарамтад өртөх вий” гэсэн айдастай байдаг байна.

Судалгаанд хамрагдсан байгаль хамгаалагчид бүгд (100,0%) “байгаль хамгаалагчийн ажил нь амь нас, эрүүл мэндэд халтай ажил” гэж үздэг аж.

Байгаль хамгаалагчид ийм эрсдэлтэй нөхцөлд ажиллаж, зарим тохиолдолд халдлагад өртөж эрсдэж байхад хэн хамгаалдаг вэ? Үүнээс хуулийн байгууллага хамгаалж чаддаг уу?

Байгаль хамгаалагчдыг хуулийн байгууллага “маш сайн” хамгаалдаг гэж 2,9% нь, “сайн” хамгаалдаг гэж 25,0% нь, “дунд” зэрэг хамгаалдаг гэж 39,7 % нь, “муу” хамгаалдаг гэж 14,7% нь, “огт анхаарал тавьдаггүй” гэж 10,3% нь үзсэн байна. Хуулийн байгууллагын хамгаалалтад 70 гаруй хувь нь итгэдэггүй байна.

Харин тухайн байгаль хамгаалагчийг харъяалдаг байгууллагын удирдлага нь “маш сайн хамгаалдаг” гэж 2,9% нь, “сайн хамгаалдаг” гэж 42,7% нь, “дунд” зэрэг хамгаалдаг гэж 20,6% нь, “муу хамгаалдаг” гэж 13,2% нь, “огт анхаарал тавьдаггүй” гэж 8,8% нь үзсэн байна. Өөрөөр хэлбэл байгаль хамгаалагчдын 45 орчим хувь нь удирдлагын зүгээс байгаль хамгаалагчаа хамгаалах талаар гаргаж буй сэтгэл, үйлдэл нь шаардлага хангахгүй байна гэж үздэг аж.

Байгаль хамгаалагчид ажлын байрандаа (мөн гэртээ) аюулгүй нөхцөлд ажиллах, амьдрах шаардлагатай байдаг боловч ийм байдал төдийлөн хангагддаггүй байна. Ажлын байранд аюулгүй байдлыг хангахад удирдлагын зүгээс “огт чухалд авч үздэггүй” гэж 7,4% нь үзсэн бол 19,1% нь “ховорхон” гэж, 22,1% нь “хааяа”, 16,2% нь “ихэнхдээ”, 30,9% нь “үргэлж” анхаардаг гэсэн байна. Энэ асуудлаар удирдлагын зүгээс хангалттай анхаарал тавьж чаддаггүй гэж 50 гаруй хувь нь үздэг байна.

Судалгаанд хамрагдагсдын 26,5% нь байгаль хамгаалагчдын сэтгэл санаа, биед эрсдэлтэй үйл явдлын дараа удирдлагын зүгээс асуудлыг “үргэлж” хурдан шийдвэрлэдэг гэж үзсэн бол 14,7% нь “ихэнхдээ” хурдан шийдвэрлэдэг гэж үнэлдэг байна. Харин 16,2% нь “хааяа”, 23,5% нь “ховорхон”, 14,7% нь “огт үгүй” гэж үздэг байна. Өөрөөр хэлбэл 55 орчим хувь нь энэ асуудлаар удирдлагууд хандлагаа өөрчлөх шаардлагатай гэж үздэг байна.

Ажлын байран дээрх байгаль хамгаалагчдынхаа эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах сургалт, хөтөлбөрийг зохион байгуулах тал дээр 37,1% нь “шаардлага хангахгүй” байна гэж үздэг бол 4,4% нь ерөөсөө ийм хөтөлбөр байдаггүй гэж үздэг байна.

Байгаль хамгаалагчдын эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангахад удирдлагуудын идэвх “сул” гэж 45,6% нь үнэлсэн байна.

Байгаль хамгаалагчдын 64,7% нь галт зэвсгийн сургалтад хамрагдаж үнэмлэх, эрх авах шаардлагатай гэж үзсэн байна (Хавсралт V.5).

5.5. Байгаль хамгаалагчдын ажиллах нөхцөл, сэтгэл зүйн байдал

Ажил үүрэгтэй холбоотой асуудал, хүндрэл тулгарвал “хамт олондоо хандана” гэж 57,4% нь, 42,6% нь “удирдлагадаа хандана” гэж боддог байна. Өөрөөр хэлбэл удирдлагаасаа илүү хамт ажиллагсаддаа найддаг байна.

Байгаль хамгаалагчдын сэтгэл санааны гутралд орох, тавгүйтэхэд олон хүчин зүйл нөлөөлдөг. Байгаль хамгаалагчдын дийлэнх нь санхүүгийн байдал голлон нөлөөлдөг гэж үздэг байна. Харин санхүүгийн байдал нь “маш их нөлөөлдөг” гэж 22,1% нь, “Их нөлөөлдөг” гэж 23,5% нь үзсэн бол 22,1% нь “дунд” зэрэг нөлөөлдөг гэж үзсэн байна. Харин 11,8% нь “бага”, 10,3% нь “огт нөлөөлдөггүй” гэж үзсэн байна. Тодруулж асуухад санхүүгийн байдал “бага” нөлөөлдөг буюу “огт нөлөөлдөггүй” гэж хариулсан хүмүүс ардаа дэлгүүр ажиллуулдаг, олон малтай зэрэг аж ахуй эрхэлдэг хүмүүс байна.

Сэтгэл санааны байдалд ажлын онцлог нь багагүй нөлөөлдөг байна. Ажлын онцлог “Маш их” нөлөөлдөг гэж 16,2% нь, “Их” нөлөөлдөг гэж 23,5% нь, “Дунд” зэрэг нөлөөлдөг гэж 23,5% нь, “бага” нөлөөлдөг гэж 2,9% нь, “огт нөлөөлөөгүй” гэж 23,5% нь үзсэн байна. Ажлын онцлог нь сэтгэл санааны байдалд “бага” нөлөөлсөн буюу “огт нөлөөлөөгүй” гэж өнгөж 26,4% нь үзсэн бөгөөд эдгээр нь ихэвчлэн шинээр ажилд орсон хүмүүс байв.

Өөрийн амь настай холбоотой санаа зоволт сэтгэл санааны байдалд “маш их” нөлөөлсөн гэж 14,7% нь, “их” нөлөөлсөн гэж 8,8% нь, “дунд” зэрэг нөлөөлсөн гэж 17,6% нь үзсэн бол “бага” нөлөөлсөн гэж 13,2% нь, “огт нөлөөлөөгүй” гэж 32,4% нь үзсэн байна.

Зарим байгаль хамгаалагчид, ялангуяа сумын байгаль хамгаалагчид удирдлагын зүгээс өгдөг үүрэгт ажилтай нь төдийлөн холбоогүй үүрэг даалгавраас залхдаг байна. Ажлын байран дээрх үүрэг даалгавраас залхдаг гэдэг асуудалтай

11,8% нь “бүрэн санал нийлнэ”, 19,1% нь “зарим талаар санал нийлнэ” гэж боддог байна (Хавсралт V.6).

6. Байгаль хамгаалагчдын нийгмийн баталгаа

6.1. Цалин орлого, хангамж, статус

Байгаль хамгаалагчдын тавьж буй гол хүсэлт нь “цалингийн хэмжээг нэмэгдүүлэх” асуудал байдаг.

Цалин нь амьдралд хүрэлцдэг эсэх асуултад судалгаанд хамрагдагсдын 16,2% нь “боломжийн” гэж хариулсан бол 32,3% нь “муу хүрэлцдэг”, 47,1% нь “огт хүрэлцдэггүй” гэж хариулсан байна. Өөрөөр хэлбэл 5 байгаль хамгаалагч тутмын 4 нь цалин нь амьдралд хүрэлцдэггүй гэж үздэг байна.

Ажилтайгаа холбоотойгоор өөрчлөгдвөл зохих зүйлүүдэд голлон цалин, санхүүгийн тусламж, удирдлагын дэмжлэгийг голлон нэрлэсэн байна. Цалингийн хэмжээ өөрчлөгдөх хэрэгтэй гэж 89,7% нь, цалингаас гадна тусламж хэрэгтэй гэж 48,5% нь, өвчтэй үеийн тусламж дэмжлэг хэрэгтэй гэж 36,8% нь үзсэн байна. Мөн 48,5% нь мэргэжлийн сургалт хөгжүүлэлт тогтмол бус байдгийг, 29,4% нь удирдлагын зүгээс ажилтай нь холбоотой чиглүүлэг тааруу байдгийг, 29,5% нь зааварчилгаа дэмжлэг муу байдгийг өөрчлөх нь зүйтэй гэж үзсэн байна. Түүнээс гадна урт цагаар ажиллуулдгийг, стресс бухимдалтай үед дэмжлэг үзүүлдэггүй байдлыг ч өөрчлөх шаардлагатай гэж үздэг байна.

Байгаль хамгаалагчдын хувьд Төрийн захиргааны (ТЗ), эвсэл төрийн үйлчилгээний (ТҮ) ажилтан байхын аль нь зохимжтой болох талаар одоо хүртэл маргалдсаар л байдаг.

Төрийн үйлчилгээний ажилтан байх нь төрийн албан хаагчийн шалгалтад заавал орох шаардлага тавигддаггүй, шалгалтад унаж байгаль хамгаалагчаар ажиллах эрхээ хасуулах зэрэг эрсдэл байдаггүй, цалин харьцангуй өндөр байх боломжтой зэрэг давуу талтай боловч ажлаасаа халагдах, төрийн албан хаагчийн хангамж эдэлдэггүй, ажлаасаа удирдлагын үзэмжээр халагдах эрсдэл өндөр зэрэг сул талд байдаг байна.

Төрийн захиргааны ажилтан байх нь дээрх нөхцлөөс урвуу байдаг. Хөдөө уулын мухарт ажилладаг байгаль хамгаалагчид төрийн захиргааны ажилтны өндөр шалгуурыг тавих нь нийцэл муутай бөгөөд өндөр боловсролтой, хатуу шалгуурыг давах чадвартай нь тэнд ажиллах сонирхолгүй байдаг зэрэг анхаарах, харгалзах нөхцлүүд бий.

Судалгаанд хамрагдсан байгаль хамгаалагчдын 30,9% нь “төрийн үйлчилгээний” ажилтан байх нь зөв гэсэн бол 64,7% нь “төрийн захиргааны” ажилтан

байх нь зүйтэй гэж үздэг байна. Энэ нь ТЗ байх нь төрийн захиргааны албан хаагчид төрөөс илүү хангамж, нөхцлөөр хангагдсан байдаг гэсэн ойлголтоос гадна сумын төвд байрладаг байгаль хамгаалагчдын ихэнх нь боловсролын бакалавр зэрэгтэй, төрийн албаны шалгалтад тэнцэх боломжтой хүмүүс байдагтай холбоотой байж болох юм.

Байгаль хамгаалагчид маань цагдаа нар хуулийн дагуу төрд өөрсдөөс нь илүү хамгаалагддаг, ажиллах нөхцөл хангамж, хууль зөрчигчидтэй харилцахад эрхээр илүү гэж ойлгодог. Байгаль хамгаалагчдын статус нь “цагдаагийн албан хаагчтай адил” байх хэрэгтэй гэж 73,5% нь үзсэн бол 30,9% нь “энгийн иргэний адил” байх хэрэгтэй гэж үзсэн байна. Хэдийгээр “Эрүүгийн тухай” хуулийн 4.2-т “хууль сахиулагч” гэдэгт цагдаа, тагнуул, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажилтнуудтай адил байгаль хамгаалагчдыг тооцдог боловч хуулийн хэрэгжилт нь ялгавартай хэвээр байдгаас ийм дүгнэлт гаргахад хүргэсэн байж болох талтай.

Байгаль хамгаалагч нь ямар үүргийг илүүтэй анхаарч гүйцэтгэх нь зүйтэй байдаг талаар өөр өөр бодолтой байна. Энэ нь ур чадвар, насны ялгаа төдийгүй сонирхлын ялгаатай байдлаас хамаардаг байна.

Байгаль хамгаалагчдын 77,9% нь хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, 61,8% нь суртал ухуулга хийж гэгээрүүлэх, 63,2% нь мониторинг судалгааны мэдээлэл цуглуулах, байгалийн төлөв байдлыг үнэлэхэд оролцох, 48,5% нь орчны бохирдлыг бууруулахад чиглэсэн ажил хийх гэж үздэг байна.

Байгаль хамгаалагчдын цалин, орлого бага гэж ярьдаг боловч үүнээс өөр орлого байдаг эсэхийг судалсан.

Судалгаанд хамрагдагсдын 52,9% нь малын ашиг шимээр нэмэлт орлого олдог бол 22,1% нь өрхийн орлогод гэр бүлийн хүний цалин нэмэр болдог гэж, 11,8% нь хүүхдийн мөнгө зэрэг халамж, тэтгэмж нэмэлт орлого болдог бол, 5,9% нь хөтөч газарч хийх зэргээр улирлын чанартай ажлаар бага зэргийн нэмэлт орлого олдог байна.

Ер нь байгаль хамгаалагчаар байгаль хамгаалах ажилд хир зэрэг элэг сэтгэлтэй, сонирхолтой хүмүүс ажилладаг болохыг тодруулахыг оролдов.

Байгаль хамгаалагчаар ажиллаж байгаа хүмүүсийн 66,2% нь өөрийн хүсэл сонирхлоороо ажиллаж байгаа бол 10 орчим хувь нь “олдсон ажил” нь гэсэн байдлаар ажилладаг байна.

Байгаль хамгаалагч нь байгалийн нөөцийг хууль бусаар ашигладаг хүмүүстэй зөрчилдөж тэдний хууль бус үйлдэлд саад болж байдаг тул орон нутгийн зарим иргэд дурамжхан ханддаг нь бодит үнэн юм.

Байгаль хамгаалагчдыг нутгийн бусад иргэдийн 86,8% нь сайнаар хүлээж авдаг бол 10 хүрэхгүй хувь нь дурамжхан хүлээж авдаг аж. Ялангуяа модны бизнес эрхэлдэг хүмүүс тааламжгүй ханддаг байна (Хавсралт V.7).

6.2. Зөвлөмж

- Байгаль хамгаалагчдын цалинг нэмэх боломжийг судалж шийдвэрлэх,
- Өвчтэй, эмнэлгээр үйлчлүүлж байх үед нь, ялангуяа албан үүрэгтэй нь холбоотойгоор халдлагад өртсөний улмаас бэртсэн, гэмтсэн үед нь санхүүгийн дэмжлэг үзүүлэх асуудлыг шийдвэрлэх,
 - Байгаль хамгаалагчдад халдсан тохиолдол бүрд “Эрүүгийн хууль”-ийн 4.2 дахь заалтыг баримтлан “хууль сахиулагчид халдсан” гэж үзэж хатуу арга хэмжээ авч байхыг хуулийн байгууллагын ажилтнууд анхаарах, байгаль хамгаалагчийн харьяалах удирдлагууд шаардаж байх,
 - Мэргэжлийн сургалт, хөгжүүлэлтийг удирдлагууд хөтөлбөрийн дагуу тогтмол зохион байгуулах,
 - Удирдлагууд мэргэжлийн чиглүүлэх зөвлөмж, зааварчилгааг байнга өгч байх,
 - Байгаль хамгаалагчдыг ТЗ-ийн шалгалтад ороход нь байгууллагын зүгээс тусалж бэлтгэж байх,
 - Байгаль хамгаалагчийг гэр бүлээрээ хийдэг. Иймд байгаль хамгаалагчдын гэр бүлийг жижиг үйлдвэрлэл эрхлэхэд дэмжлэг үзүүлэх,
 - Байгаль хамгаалагчдыг гэнэтийн осол, амь насны даатгалд төрөөс даатгаж байх ,
 - “Байгаль хамгаалагчдын сургалт, ажлын байр, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг Монголын байгаль хамгаалагчдын холбоо”-ноос боловсруулан БОАЖЯ-нд хүлээлгэн өгснийг (хүлээлгэн өгсөн хувилбарыг VII.9-д хавсаргасан) зарим нэг өөрчлөлт оруулан баталсан байна. Бидний хувилбар ба батлагдсан хувилбарыг харьцуулан цаашид улам сайжруулах арга хэмжээ авах.

7. Хавсралтууд

VII.1 Аман судалгааны асуулга



№.....

БАЙГАЛЬ ХАМГААЛАГЧДААС АВАХ САНАЛ, АСУУЛГА

Аймаг..... сум..... байгууллага.....

ХЭСЭГ 1. Байгаль хамгаалагчийн мэдээлэл:

1. Төрсөн он сар өдөр _____
2. Таны хүйс? Эрэгтэй [] Эмэгтэй []
3. Гэр бүлийн байдал? Ганц бие [] Гэрлэсэн [] Гэр бүл цуцалсан [] Бэлэвсэн []
4. Таны боловсролын түвшин? Дунд боловсрол [] Бүрэн дунд боловсрол [] ТМС []
Тусгай дунд (техникум, коллеж) [] Их сургууль (төгсөөгүй) [] Их сургууль (төгссөн) []
Магистр [] Ямар сургууль, ямар мэргэжлээр
5. Таны эрхэлдэг үндсэн ажил?
Байгаль орчны хяналтын улсын байцаагч [] Сумын байгаль хамгаалагч [] Тусгай хамгаалалттай газрын байгаль хамгаалагч [] Байгаль хамгаалагч бол байгаль орчны хяналтын улсын байцаагчийн эрхтэй эсэх [] Идэвхтэн байгаль хамгаалагч []
Байгаль хамгаалагч биш боловч байгаль хамгаалах үүрэг бүхий албан тушаалтан (сумын Засаг дарга,)
6. Та хэдэн жил ажилласан бэ? 5 хүртэл жил [] 5 – 10 жил [] 10-аас дээш жил []
7. Гэрийн байршил? Сумын төвд [] Төв суурин газраас хол газарт [] Бусад []
8. Ам бүлийн тоо: []
9. Хүүхэд бүрийн насыг бичнэ үү. Том хүүхэд [], 2 дах хүүхэд [], 3 дах хүүхэд [], 4 дах хүүхэд [], 5 дах хүүхэд [], 6 дах хүүхэд []
10. Хүүхдүүд бага [], дунд [], дээд [] сургуульд суралцдаг.

ХЭСЭГ 2. Сургалтын хэрэгцээ

1. Байгаль хамгаалагчаар ажиллах хугацаандаа хэдэн удаагийн сургалтанд хамрагдсан бэ? []
2. Та ямар төрлийн сургалтуудад хамрагдсан бэ?
 - Мэргэжлийн ур чадвар хөгжүүлэх сургалт []
 - Аюулгүй ажиллагааны сургалт []
 - Тоног төхөөрөмж ашиглах зааварчилгаа сургалт []
 - Хувийн хөгжлийн сургалт []
 - Бусад []

3. Сургалтын үр дүнд хэр сэтгэл ханамжтай байгаа вэ?
Маш сайн [] Сайн [] Боломжийн [] Сайнгүй [] Маш муу []
4. Сургалтын дараа таны ажлын чанарт ахиц, өөрчлөлт гарсан уу?
Маш сайн [] Сайн [] Боломжийн [] Сайнгүй [] Маш муу []
5. Сургалтын хөтөлбөр өмнөх жилүүдийнхээс сайжирсан уу?
Маш сайн [] Сайн [] Боломжийн [] Сайнгүй [] Маш муу [] Мэдэхгүй []
6. Та сургалтын дараа мэргэжлийн үнэмлэх, сертификат авсан уу?
Тийм [] Үгүй []
7. Сургалтын дараа цалин, нэмэгдлийн хэмжээ өөрчлөгддөг үү?
Тийм [] Үгүй []
8. Та цаашдаа ямар **төрлийн сургалтанд** хамрагдах хүсэлтэй байна вэ?
- *Мэргэжлийн ур чадвараа хөгжүүлэх []*
 - *Аюулгүй ажиллагааны сургалт []*
 - *Тоног төхөөрөмж ашиглах зааварчилгаа сургалт []*
 - *Хувийн хөгжлийн сургалт []*
 - *Бусад: (нэрлэнэ үү)*
-

9. Та өөрийн **боловсролын түвшинг ахиулах** хүсэлтэй байдаг уу?
Тийм [] Үгүй []

Хэрвээ тийм бол, хэрхэн ахиулахыг хүсдэг вэ?

10. Байгаль хамгаалагчийн ажлын байрны тодорхойлолтод боловсрол, мэдлэгийн шаардлага нь бодит байдалд нийцэлтэй байдаг уу?
Тийм [] Үгүй []

ХЭСЭГ 3. **Ажлын байрны нөхцөл**

Ажлын байрны аюулгүй байдал

1. **Ажлын байрны нөхцөл нь** таны үүрэгт ажлаа гүйцэтгэхэд тохиромжтой байдаг уу?
Тийм [] Үгүй []

2. Үүрэгт ажлаа гүйцэтгэхэд шаардлагатай **техник болон бие хамгаалах хэрэгслэлээр** хангагдсан эсэх: (Өөрт тохирох хариултуудыг чагтална уу.)

- Унаа: Машин [] Мотоцикл [] Морь []
- Ажиглах хэрэгсэл: Дуран [], холын дуран (spotting scope, spangoscope) []
- Баримтжуулах хэрэгсэл: Зургийн аппарат [] Дрон [] дуу хураагч []
- Холбооны хэрэгсэл: Богино долгионы станц [] Утас [] сансрын утас []
- Бие хамгаалах хэрэгслэл: Галт зэвсэг [] бусад []
- Бусад:

3. Та албан үүргээ гүйцэтгэж байхдаа **халдлага дарамтад өртөж** байсан уу?
Тийм [] Үгүй [] Надад тохиромжгүй асуулт байна []

4. **Хамтран ажиллагсдаас** албан үүргээ гүйцэтгэж байхдаа халдлага, дарамтанд өртөж байсан уу?
Тийм [] Үгүй [] Надад тохиромжгүй асуулт байна []

5. Танд албан үүргээ гүйцэтгэж байхдаа **халдлага дарамтад өртөх вий гэсэн айдас түгшүүр** байдаг уу?
Тийм [] Үгүй [] Надад тохиромжгүй асуулт байна []

6. Байгаль хамгаалагчдыг гадны халдлага, дарамтаас **удирдлагууд хэрхэн** хамгаалдаг вэ?
Маш сайн [] Сайн [] Дунд зэрэг [] Муу [] огт анхаарал тавьдаггүй [] Надад тохиромжгүй асуулт байна []
Тийм бол хэрхэн хамгаалдаг вэ?

7. Таныг гадны халдлага, дарамтаас таныг хамгаалахад **хуулийн байгууллага хэрхэн хамгаалдаг вэ?**
Маш сайн [] Сайн [] Дунд зэрэг [] Муу [] огт анхаарал тавьдаггүй [] Надад тохиромжгүй асуулт байна []
Тийм бол хэрхэн хамгаалдаг вэ?

8. Таныг гадны **халдлага, дарамтаас хамгаалах тогтолцоо** байдаг уу?
Тийм [] Үгүй [] Надад тохиромжгүй асуулт байна [] Мэдэхгүй []
Тийм бол нэрлэнэ үү.

9. Байгаль хамгаалагчийн ажил нь амь нас, эрүүл мэндэд халтай ажил уу?
Тийм [] үгүй []

10. Тийм бол шалтгааныг нэрлэнэ үү?

Ажлын байран дахь аюулгүй байдлын удирдлага

11. Манай **удирдлагын зүгээс** ажлын байран дээрх аюулгүй байдлыг чухалд авч үздэг.
А. Огт үгүй Б. Ховорхон В. Хааяа Г. Ихэнхдээ Д. Үргэлж

12. Эрсдэлтэй, аюултай зүйлсүүдийг удирдлагын зүгээс **эрсдлийг нь бууруулдаг.**
А. Огт үгүй Б. Ховорхон В. Хааяа Г. Ихэнхдээ Д. Үргэлж

13. Сэтгэл санаа, биенд эрсдэлтэй үйл явдлын дараа удирдлагын зүгээс **асуудлыг хурдан шийдвэрлэдэг.**
А. Огт үгүй Б. Ховорхон В. Хааяа Г. Ихэнхдээ Д. Үргэлж Е. Тохиолдол гараагүй

14. Манай байгууллага ажилтнуудынаа ажлын байран дээр эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах **сургалт хөтөлбөрийг** зохион байгуулдаг.

А. Огт үгүй Б. Ховорхон В. Хааяа Г. Ихэнхдээ Д. Үргэлж Е. Ийм хөтөлбөр байдаггүй

15. Эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалахад **удирдлагууд идэвхтэй оролцдог.**

А. Огт үгүй Б. Ховорхон В. Хааяа Г. Ихэнхдээ Д. Үргэлж

16. Өөрсдийн эрүүл мэнд, аюулгүй байдлын талаар **удирдлагуудтай үргэлж ярилцдаг.**

А. Огт үгүй Б. Ховорхон В. Хааяа Г. Ихэнхдээ Д. Үргэлж

17. Галт зэвсгийн сургалтад хамрагдан сертификат авах шаардлага бий эсэх?

Бий [] Байхгүй []

Ажлын байран дахь чиглүүлэг, дэмжлэг

18. Таны ажилд хэрэгтэй чиглүүлэг **дэмжлэгийг хамт олноосоо** авдаг уу?

Маш сайн [] Сайн [] Боломжийн [] Сайнгүй [] Маш муу []

19. Таны ажилд хэрэгтэй **чиглүүлэг дэмжлэгийг байгууллагаасаа** авдаг уу?

Маш сайн [] Сайн [] Боломжийн [] Сайнгүй [] Маш муу []

20. Хэрвээ танд ажил үүрэгтэй холбоотой асуудал, хүндрэл тулгарвал **хэнээс тусламж дэмжлэг** авах вэ?

Хамт олон [] Удирдлага [] Байгууллага [] Иргэд [] Бусад []

Сэтгэл санаа, мэнд

21. Өнгөрсөн жилийн хугацаанд өөрийн **сэтгэл санааг** ерөнхийдөө ямар байсан гэж үнэлэх вэ?

Маш сайн [] Сайн [] Боломжийн [] Сайнгүй [] Маш муу []

22. Сэтгэл санааны энэ байдалд дараах **хүчин зүйлсээс аль нь нөлөөлсөн** бэ?

Нөлөөлсөн зүйлсийг 1 (огт нөлөөлөөгүй) онооноос 5 (ихээр нөлөөлсөн) онооны хооронд үнэлнэ үү. Дурдагдаагүй хэсгийг нэмж бичиж болно.

- Ажлын онцлог [1] [2] [3] [4] [5]

- Санхүүгийн байдал [1] [2] [3] [4] [5]

- Гэр бүлийн байдал [1] [2] [3] [4] [5]

- Өөрийн амь настай холбоотой санаа зоволт [1] [2] [3] [4] [5]

- COVID-19 цар тахал [1] [2] [3] [4] [5]

23. Өнгөрсөн жилийн туршид таны биеийн эрүүл мэнд болон сэтгэл санааны байдалд ажлаас нөлөөлөх нөлөө байсан уу?

Эерэг нөлөөтэй [] Сөрөг нөлөөтэй [] Огт нөлөөгүй []

Шалтгаан: _____

24. Цаг явах тусам би өөрийн хийдэг ажлаасаа холдож байгаа!

Бүрэн санал нийлнэ [] Зарим талаарсанал нийлнэ [] Зарим талаар санал нийлэхгүй [] Огт санал нийлэхгүй []

25. Заримдаа би ажлын байран дээрх үүрэг даалгавраасаа залхдаг.

Бүрэн санал нийлнэ [] Зарим талаарсанал нийлнэ [] Зарим талаар санал нийлэхгүй [] Огт санал нийлэхгүй []

26. Би өөрийгөө ирээдүйд зөвхөн энэ ажлыг хийж буйгаар төсөөлдөг.
Бүрэн санал нийлнэ [] Зарим талаарсанал нийлнэ [] Зарим талаар санал
нийлэхгүй [] Огт санал нийлэхгүй []

ХЭСЭГ 4. Нийгмийн баталгаа

1. Таны хувьд ажилтайгаа холбоотой ямар зүйлс **сайжрах, өөрчлөгдөх** хэрэгтэй гэж боддог вэ?

- Цалин []
- Цалингаас гадна тусламж дэмжлэг []
- Өвчтэй үеийн тусламж дэмжлэг []
- Мэргэжлийн сургалт хөгжүүлэлт []
- Удирдлагын зүгээс ажилтай холбоотой чиглүүлэг, зааварчилгаа, дэмжлэг байхгүй байдал []
- Урт цагаар ажиллах байдал []
- Ажилтай холбоотой стресс бухимдал []
- Ажлаас гадуурх стресс бухимдал []
- Бусад:

2. Байгаль хамгаалагч нь **ямар үүргийг** илүү анхаарч гүйцэтгэх нь зүйтэй гэж үздэг вэ?

- Хуулийн хэрэгжилтэд хяналт тавих []
- Суртал ухуулга хийх, гэгээрүүлэх []
- Байгалийн нөхцөл байдлыг үнэлэхэд шаардлагатай анхан шатны мэдээлэл цуглуулах, судалгаанд оролцох []
- Орчны бохирдлыг бууруулахад чиглэсэн ажил хийх (хог цэвэрлүүлэх) []
- Зөвшөөрөл олгох []
- Бусад: _____

3. Байгаль хамгаалагчид аль нь **илүү зохимжтой** вэ?

- Төрийн үйлчилгээ (ТҮ) [] Төрийн захиргаа (ТЗ) []

4. Байгаль хамгаалагчийн **статус** ямар байвал зохимжтой гэж үздэг вэ?

- Цагдаагийн албан хаагчтай адил []
- Энгийн иргэний []

5. Таны **цалин** таны амьдралд **хүрэлцээтэй** байдаг уу?

- Маш хангалттай [] Сайн [] Боломжийн [] Сайнгүй [] Маш муу []

6. Орон нутагт ямар нэмэгдэл авах боломжтой гэж үздэг вэ?

.....

7. Та өөрийн **орлогын эх үүсвэрүүдийг** сонгоно уу?

- Цалин [] Малын ашиг шим [] Улирлын чанартай ажил [] Гэр бүлийн хүний

цалин [] Улсын халамж, тэтгэмж [] Бусад орлого []

8. Та байгууллагаас төлдөг ямар нэг даатгалд хамрагдсан эсэх?

- Амь насны []
- Эрүүл мэндийн []
- Гэнэтийн ослын []
- Нийгмийн даатгал []
- Бусад []

9. Та өөрийн хийдэг ажлыг бусдад санал болгох уу?

Дуртайяа санал болгоно [] Санал болгоно [] Санал болгохгүй [] Огт санал болгохгүй []

10. Ямар нэг нэмэгдэл авдаг эсэх?

Авдаг [] авдаггүй []

ХЭСЭГ 5: Дэлгэрэнгүй тайлбарлаж болох:

1. Та байгаль хамгаалагчийн ажлын байрыг сонгосон шалтгаан нь юу вэ?

.....

2. Ажиллаж байх хугацаанд тань таны хувь хүний үнэт зүйлс өөрчлөгдсөн үү?

Өөрчлөгдсөн [] өөрчлөгдөөгүй []

3. Таныг байгаль хамгаалагчийн үүрэгт ажлын хүрээнд бусад хүмүүс таныг хэрхэн хүлээж авдаг вэ?

Маш сайн [] хэвийн [] дурамжхан [] маш дургүй []

4. Та байгууллагынхаа үйл ажиллагаанд шүүмжлэлтэй ханддаг уу?

Тийм [] Үгүй [] Шүүмжлэх шаардлагагүй []

5. Ажлын байран дээрээ та амжилттай ажилласан мэдрэмжийг авдаг уу?

Авдаг бол хэзээ авч байсан бэ?

6. Таны ажлын байрандаа хийдэг ажлууд таны хувьд хир зэрэг үнэ цэнэтэй вэ?



Их [] дунд зэрэг [] бага []

7. Та ажлын байрандаа хэнтэй хамгийн их холбоотой ажилладаг вэ?

.....

“Монголын байгаль хамгаалагчдын холбоо” ТББ



VII.2. Судалгаанд хамрагдсан байгаль хамгаалагчдын мэдээлэл





VII.3. Байгаль хамгаалагчдын сургалтын үр нөлөө ба хэрэгцээ




VII.4. Байгаль хамгаалагчдын ажлын байрны нөхцөл, эрсдэл




VII.5. Байгаль хамгаалагчдын ажилтай нь уялдсан халдлага, эрсдэл, тэднийг хамгаалах тогтолцоо





VII.6. Байгаль хамгаалагчдын ажиллах нөхцөл, сэтгэл зүйн байдал







VII.7. Байгаль хамгаалагчдын нийгмийн баталгаа



Байгаль хамгаалагч нь ямар үүргийг илүү анхаарч гүйцэтгэх нь зүйтэй гэж үздэг вэ?




Байгаль хамгаалагчид аль нь илүү зохимжтой вэ?




Байгаль хамгаалагчийн статус ямар байвал зохимжтой гэж үздэг вэ?




Таны цалин таны амьдралд хүрэлцээтэй байдаг уу?




Та өөрийн орлогын эх үүсвэрүүдийг сонгоно уу?



Та байгаль хамгаалагчийн ажлын байрыг сонгосон шалтгаан нь юу вэ?



Таныг байгаль хамгаалагчийн үүрэгт ажлын хүрээнд бусад хүмүүс таныг хэрхэн хүлээж авдаг вэ?



VII.8. TERMS OF REFERENCE

TO EVALUATE THE WORKPLACE CONDITIONS OF TARGET TERRITORIAL RANGERS

Name/Location	Assess the working condition and demand/need of rangers in the target area
Application deadline	20 Oct, 2021
Type of Contract	Institutional contract
Post Level	Legal entity/NGO
Languages required:	Mongolian and English
Duration of Initial Contract:	2 Months

A. BACKGROUND

The ENSURE project aims to enhance ecosystem services in multiple landscapes of the Sayan and Khangai mountains and southern Gobi by reducing rangeland and forest degradation and conserving biodiversity through sustainable livelihoods. The project strategy is to engage multiple stakeholders to deliver the following four project outcomes:

Rangelands, forests and biodiversity are restored, and protected areas strengthened at landscape scale. Key results will include reduced degradation of 300,000 ha of rangelands, plus 20,000ha of boreal and 25,000 ha of saxaul forests, protected area system expanded by 0.94 million ha and strengthened, and threats to globally threatened / iconic biodiversity reduced.

The territories of the target aimags are located in four major eco-regions of Mongolia notably Altay Sayan, Khangai, Central Asian Gobi and Desert, and sub-regions of Southern Gobi and Gobi Altay of Great Lakes' Depression covering 13 soums of Arkhangai, Zavkhan, Bayankhongor and Gobi-Altai aimags.

In accordance to the decision of the Project Board Meeting on budget revising at 24 Sep, 21 an activity "Assess the working condition and demand/need of rangers in the target area and provide them necessary equipment" is planned as 2.3.7 activity in the Project Activity Plan 2021 and its revised budget. Under this activity there is an assessment will be conducted on the actual working condition and demand/needs of the rangers in vertical and horizontal state environmental inspection systems.

B. DUTIES AND RESPONSIBILITIES

Main goal of this assignment is to identify the real needs and requirements of rangers in project target area via desk review combined with a rapid assessment on their working conditions; and to develop justification/recommendations to solve their facing issues related to current legal environment and workplace which all rangers (souv ranger, ranger of special protected area, ranger with a status of state

environmental inspector and volunteer ranger) belong to.

The objectives of this assignment are:

- To assess the current situation of soum ranger, ranger of special protected area, ranger with a status of state environmental inspector and volunteer ranger in project target area;
- Based on the assessment to identify rangers’ real demand/needs for specific inspection or duty and suggest specific solutions to improve coordination and management. In particular, to analyze relevant legislative acts and human resources capacity issues associated with their workplace requirements and develop recommendations.
- To develop a model for assessing the working conditions of all rangers that can be useful at a national scale.

Scope of Work:

Within the framework of the service contract, following activities shall be conducted:

1. Desk review and research on current situation of the rangers in project target area and results;
2. Identify actual demand/needs of the rangers based on the assessment (desk review and field research);
3. Analysis of current legal environment and human resource issues related to the rangers’ conditions and workplace;
4. Develop justification/recommendations to solve rangers’ facing issues
5. Develop a standard model for assessing the working conditions of all rangers and disseminate;

Duty Station:

13 soums of 4 aimags belonging to the project target area.

C. EXPECTED DELIVERABLES AND PAYMENT SCHEDULE

Deliverables	Estimated duration to complete/ Target due dates*	Payment installments	Review & approvals
1. Inception report: <ul style="list-style-type: none"> • Introduce the action plan, methodology, and expected results to the project implementation unit in accordance with the terms of reference, and mutually agree on the plan. 	Within 10 days from start of contract, 1 Nov 2021	60% after the inception report discussed with National Association members/MET and accepted	Respective UNDP CO and PIU
2. Progress Report: <ul style="list-style-type: none"> • Current the situation of the work in accordance with the mutually agreed 	01 Dec 2021	20% after the progress	

<p>action plan, analysis of the collected data and information, methodology and results to the project implementation unit and the project consulting team.</p>		<p>report discussed and accepted</p>	
<p>3. Final report:</p> <ul style="list-style-type: none"> • Provide consulting services in a professional manner in accordance with the terms of reference, develop the results of the work, present the final report of the consulting services to the project implementation unit, project consulting team and project technical working group, reflect their suggestions and submit to the funder; • Develop recommendations for further action; • Shape files of the maps. 	<p>Within 3 days once the completed contractual services 20 Dec 2021</p>	<p>20% after the final report discussed and accepted</p>	

* Target due dates are subject to change upon prior notification.

D. INSTITUTIONAL ARRANGEMENT

This assignment should be conducted only a professional legal entity that has a special license to operate for conducting measures of nature resource and special protected area management.

Contractor is expected to work in close collaboration with PIU, UNDP CO and other relevant stakeholders. Also it should have a team members with at least 5 years of professional experience in nature conservation to carry out this assignment.

The team leader shall have overall responsibility of reporting. Criteria (technical qualifications) to evaluate the trainers is shown in Annex I.

The present ToR may be subject to modification, without changing the overall objective and the scope of work, on the basis of mutual consultations. The contract will be effective immediately upon signature by UNDP CO.

The entity should report the progress of the deliverables as indicated in the ToR to PIU and UNDP CO. They are also expected to ensure a timely identification of potential risks and signals of any delays in deliverables. It is important to highlight that the entity should use only copyrighted materials (photo, images, sound etc.) to produce the deliverables. UNDP will hold the copyright of all deliverables.

UNDP CO and Project team will have the following responsibilities: (i) Provide with relevant documents and resources; (ii) Discuss and agree on the methodologies of the assignment; and (iii) Monitor and evaluate the progress of the assignment. The contract and payments will be performance-based and regularly assessed by the UNDP CO, MET and Project team.

Duration of the Work

Duration of the work is 2 months.

Duty Station

The contractor will in Ulaanbaatar base. The assignment will involve field trips to aimags and soums. The contractor should include the costs involving the field trip in the financial proposal.

E. COMPETENCIES, REQUIRED SKILLS AND EXPERIENCE

A. Qualifications of the successful Contractor

For the legal entity to provide the service:

- At least 5 years of experience in research in the field of natural resource and special protected area management;
- Have experts who have worked in this field for more than 10 years;
- Have experience in conducting research, trainings, seminars and consulting at national and local level.

Competencies of the entity:

- Highly organized legal entity that produces quality work and meets deadlines;
- Capable of working in a high-pressure environment with sharp and frequent deadlines, managing many tasks simultaneously;
- Exercise the highest level of responsibility and be able to handle confidential and politically sensitive issues in a responsible and mature manner.

Qualification requirements for the team leader:

- At least Master degree and more in Environmental field;
- More than 10 years of experience in nature conservation and protected area management including in multiple problem solving for the rangers' in horizontal and vertical management;
- Able to manage the team members and maintain a professional relationship with UNDP CO, and stakeholders;
- Experience in interacting with local stakeholders under pressure and complicated situations is an asset;
- Working level oral and written English is desirable.

Qualification requirements for the Nature Conservation Specialist:

- University degree in Nature Conservation, Natural Resource or Protected Area Management;
- At least 5 years of extensive knowledge and professional work experience in state and locally protected area management;
- Experience in research and training;
- Working level oral and written English is desirable.

Qualification requirements for the ranger:

- Previous work experience as a State Inspector or Ranger;
- At least 5 years of extensive knowledge and professional work experience.

F. APPLICATION AND SELECTION PROCESS

Price Proposal and Schedule of Payments

Contractor must send a financial proposal based on **Lump Sum Amount**. The total amount quoted shall be all-inclusive and include all costs components required to perform the deliverables identified in the TOR, including professional fee, travel costs, living allowance (if any work is to be done outside the IC's duty station) and any other applicable cost to be incurred by the IC in completing the assignment. The contract price will be fixed output-based price regardless of extension of the herein specified duration. Payments will be done upon completion of the deliverables/outputs and as per below percentages:

- Deliverables 1 : 60% of total contract amount

- Deliverables 2 : 20% of total contract amount
- Deliverables 3 : 20% of total contract amount

Evaluation Method and Criteria

Cumulative analysis. The award of the contract shall be made to the professional service provider whose offer will be evaluated and determined as a) responsive/compliant/acceptable; and b) having received the highest score out of set of weighted technical criteria (70%). and financial criteria (30%). Financial score shall be computed as a ratio of the proposal being evaluated and the lowest priced proposal received by UNDP for the assignment.

Technical Criteria for Evaluation (Maximum 100 points)

A point-based scoring system is used for the technical criteria evaluation. Detailed breakdown of each criteria and their point is illustrated in Annex I.

Only candidates obtaining a minimum of 70 points (70% of the total technical points) would be considered for the Financial Evaluation.

Documentation required

Interested entity must submit the following documents/information to demonstrate their qualifications. Please group them into **two (2) PDF documents (technical and financial separately)** as the application only allows to upload maximum two documents:

- **Letter of Confirmation of Interest and Availability** using the template provided in Annex I.
- **Company profile** indicating all past experience from similar projects, short bio of the team members, and the contact details (email and telephone number)
- **Technical proposal**, including a) a brief description of why the professional service provider considers itself as the most suitable for the assignment; and b) a methodology, on how they will approach and complete the assignment.
- **Financial proposal**, as per template provided from procurement unit of UNDP.

Incomplete proposals may not be considered.

Approval

This TOR is approved by:

Khishigjargal Kharkhuu,

Programme Analyst, UNDP Mongolia

Annex I of ToR

Criteria	Weight	Max. Point
Technical criteria 1: Expertise of the organization		35
<ul style="list-style-type: none"> • Highly organized legal entity that capable of working in a high-pressure environment with sharp and frequent deadlines, managing many tasks simultaneously; • Must have enough experience in projects comparable with the present assignments. • Must prove this experience with at least 3 successfully completed contracts in the last 5 years; • Exercise the highest level of responsibility and be able to handle confidential and politically sensitive issues in a responsible and mature manner. 		35
Technical criteria 2: Qualification of team members		40
<u>Team leader:</u> <ul style="list-style-type: none"> • At least Master degree and more in Environmental field; • More than 10 years of experience in nature conservation and protected area management including in multiple problem solving for rangers' in horizontal and vertical management; • Able to manage the team members and maintain a professional relationship with UNDP CO, and stakeholders; • Experience in interacting with local stakeholders under pressure and complicated situations is an asset; • Working level oral and written English is desirable. 		20
<u>Team member – Nature Conservation Specialist</u> <ul style="list-style-type: none"> • University degree in Nature Conservation, Natural Resource or Protected Area Management; • At least 5 years of extensive knowledge and professional work experience in state and locally protected area management; • Experience in research and training at national and local level; • Working level oral and written English is desirable.. 		10
<u>Team member - Ranger</u> <ul style="list-style-type: none"> • work experience as a State Inspector or Ranger; • At least 5 years of extensive knowledge and professional work experience. 		10

Technical criteria 3: Proposed methodology and timeliness of the implementation plan		25
A brief proposal describing the methodologies, work plan and timeframe		15
Demonstration of quality assurance mechanisms and risk management		10
Technical Score	70	100

VII.9. Байгаль хамгаалагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр

Нэг. Хөтөлбөрийн нийтлэг үндэслэл:

1.1 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилго:

“Төрийн албаны тухай” хуулийн 55 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэргжүүлнэ” гэж заасан нь энэхүү хөтөлбөрийг боловсруулах хууль эрх зүйн үндэслэл болно.

Олон улсын байгаль хамгаалагчдын холбооноос гаргасан Читваны тунхаглалыг хэрэгжүүлэх үүднээс улс орон бүр байгаль хамгаалагчдын ажлын байрыг аюул эрсдэлгүй байлгах, амьдралын баталгааг хангаж эх дэлхий, унаган байгалиа ирээдүйд үлдээх үүднээс тусгайлсан төлөвлөгөө, хөгжлийн хөтөлбөрийг боловсруулдаг болжээ.

Байгаль хамгаалагчдын дунд хийсэн судалгаанаас үзэхэд тэдний **90.8%** нь цалингийн шатлал нэмүүлэх, **85.6%** нь хээрийн нэмэгдэл тооцуулдаг болох, **82.8%** нь орон нутагт ажилласны урамшуулал олгох, **80.4%** нь шаардлагатай багаж тоног төхөөрөмжөөр хангагдах, **78%** нь тэтгэврийн насыг наашлуулах санал гаргасан байна.

Байгаль хамгаалагчдын **41.8%** нь 400-500 мянга, **27.7%** нь 500-600 мянга, **16.9%** нь 600-700 мянган төгрөгийн цалин гар дээрээ авч байна. Тэдний **68%** нь ажлын байрандаа сэтгэл ханамжтай байдаг байна.

Энэхүү судалгаанаас харахад байгаль хамгаалагчдын цалин, урамшуулал болон илүү цагийн ажлын хөлсийг хэрхэн тооцох талаар судлах, хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага нэгэнт үүсчээ.

Мөн одоо ажиллаж байгаа байгаль хамгаалагчдыг шаардлагатай тоног төхөөрөмж, тусгай хэрэгслээр бүрэн хангах, байгаль хамгаалагчдын амь нас эрүүл мэнд, гэр бүлийн аюулгүй байдалд анхаарах, нийгмийн асуудлыг нь цогцоор шийдэх шаардлага зүй ёсоор үүссэнийг батлан харуулж харуулж байна.

Байгаль хамгааллыг дэлхий нийтийн жишигт нийцүүлэхийн тулд байгаль хамгаалагчдын ажлын нөхцөлийг бусад ажлын байрнаас онцгойлон анхаарах, байгаль хамгаалах үүрэгтэй албан тушаалтнууд, байгаль хамгаалах сонирхолтой иргэд, иргэний нийгмийн байгууллагуудын эрхийг хамгаалахад төрөөс анхаарах шаардлагатай болсон байна.

“Биологийн олон янз байдал, бидний амьдралын эх үүсвэр болсон экосистемийн тогтолцоог хамгаалахад үр дүнтэй ажилладаг, сайн дэмжигдсэн, мэргэжлийн ур чадвартай, үүрэг хариуцлагатай, байгаль хамгаалагчид” гэсэн алсын

хараа, “байгаль хамгаалагчдын нэгдмэл байдал хангагдсан, чадавхи, хөдөлмөр эрхлэлт, эрх тэгш байдал, зан үйлийн стандартыг хангахуйц мэргэжлийн, хариуцлагатай, чадварлаг “байгаль хамгаалагч” ажиллах хүчнийг бий болгох, тэдний оруулсан хувь нэмрийг албан ёсоор хүлээн зөвшөөрч, хүндэтгэх дэлхийн таатай орчин бий болгох” гэсэн олон улсын байгаль хамгаалагчдын холбооны зорилгод нийцүүлэн байгаль хамгаалагчдыг мэргэшүүлэх сургалтын хэрэгцээ, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны талаар байгаль хамгаалагчдын дунд хийсэн судалгаа дүгнэлт болон байгаль хамгаалагчдын нэгдсэн чуулганаас гарсан саналыг үндэслэн боловсруулав.

Байгаль орчин аялал жуулчлалын яамны болон орон нутгийн харъяаллын байгаль хамгаалагчдыг сургах, эрүүл мэнд, сэтгэл санааг эрсдэл, халдлагаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, ажлын байрны нөхцөл, нийгмийн баталгааг хангах замаар тасралтгүй хөгжих боломжийг олгож чадварлаг хүний нөөцийг бүрдүүлэх, эрх мэдэлтэй, урам зоригтой, хариуцлагатай, төрөөс дэмжигдсэн байх нөхцөлийг хангахад энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

Энэ хөтөлбөрийг хэрэгжүүлснээр:

-Байгаль хамгаалагчид хууль тогтоомжид заасан нийгмийн баталгаагаар хангагдах, төрийн албаны үйл ажиллагаа тасралтгүй, тогтвортой байх зарчим хангагдана;

- Чадварлаг, туршлагатай, мэргэшсэн боловсон хүчний нөөц бүрдэнэ;

- Байгаль хамгаалагчдын хувь хүний хөгжил, мэргэшлийн ур чадвар, бүтээмж дээшилнэ;

- Байгаль хамгаалагчид, тэдний гэр бүлийн оролцоог дэмжсэнээр төрийн албаны ёс зүйг баримталсан, хууль дээдэлсэн, эрүүл уур амьсгал, харилцааны эерэг хандлагыг төлөвшүүлнэ;

- Чиг үүргээ аливаа нөлөөллөөс ангид хэрэгжүүлэх нөхцөл, боломж бүрдэнэ.

- Байгаль хамгаалагчаар ажиллах сонирхолтой хүмүүсийн тоо нэмэгдэж, мэдлэг, ур чадвар өндөртэй, ёс зүйтэй байгаль хамгаалагчдын залгамж халаа бэлтгэгдэнэ.

- Байгаль хамгаалагчаа хамгаалснаар байгаль хамгаалах зорилгууд амжилттай хэрэгжинэ.

1.2 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарчим:

Байгаль хамгаалагчдын сургалтын хэрэгцээ, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх дараах зарчмыг баримтлана.

1.2.1 Хууль тогтоомж, төрийн болон хууль сахиулах салбарын баримт бичигтэй уялдсан байх.

1.2.2 Хэрэгжилт ил тод нээлттэй байх,

1.2.3 Байгаль орчны асуудал хариуцсан салбаруудын санал санаачлагад тулгуурласан, байгаль хамгаалагч нэг бүрийг хамруулсан,

1.2.4 Салбар хоорондын болон нутгийн захиргааны байгууллага, төрийн бус байгууллага, олон улсын болон гадаадын байгууллагын хамтын ажиллагаанд дэмжлэгт түшиглэх,

1.2.5 Байгаль хамгаалагчид, тэдний эрх ашгийг хамгаалах зорилго бүхий иргэний нийгмийн байгууллагын саналыг үндэслэн, хөтөлбөртөө баяжуулалт хийж нэмэлт өөрчлөлт оруулах замаар зохицуулж байх,

1.2.6. Төсөл, хөтөлбөрүүдийн тусламж, дэмжлэг нь байршлын хувьд давхцалгүй, ил тод, нээлттэй, хүртээмжтэй байх.

1.2.7. Бодитой, үр дүнтэй байх. Бусад салбарын ажилтнууд 8 цагаар ажилладаг байхад ялангуяа эрсдэл өндөр, зөрчил ихтэй газруудын байгаль хамгаалагчдад амралтын цаг байдаггүйгээс гадна илүү цагаар ажилласан нэмэгдэл олгогддоггүй байна.

1.2.8. Байгаль хамгаалал бол сэтгэлээсээ хийдэг ажил. Байгаль хамгаалагчийн хөлснөөс нь үр дүн гарч байдаг алба тул урамшуулал, урмаар дэмжих,

1.2.9. “Цалингүй байгаль хамгаалагчид” гэгдэх - байгаль хамгаалах чиг үүрэг бүхий нөхөрлөлүүд, ТББ-уудын оролцоог хангахад анхаарах.

1.3 Хөтөлбөрийн бүтэц:

I. Хөтөлбөрийн нийтлэг үндэслэл

1.1 Хөтөлбөрийн зорилго

1.2 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарчим

1.3 Хөтөлбөрийн бүтэц

1.4 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа

II. Хүний нөөцийн удирдлага, өнөөгийн байдал

2.1 Байгаль хамгаалагчийн байршил, өнөөгийн байдал

2.2 Хүний нөөцийн удирдлагын SWOT шинжилгээ

2.3 Байгаль хамгаалагчийн нөөцийн талаархи судалгаа, мэдээлэлд хийсэн дүн шинжилгээ

III. Хөтөлбөрийн зорилт түүнд хийсэн шинжилгээ

3.1 Хөтөлбөрийн зорилтууд

3.2 Зорилтуудыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

IV. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүжилтийн эх үүсвэр

V. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт, хяналт, шинжилгээ, үнэлгээ

Хоёр: Хүний нөөцийн удирдлага, өнөөгийн байдал

2.1 Байгаль хамгаалагчийн байршил, өнөөгийн байдал

Тусгай хамгаалалттай бүс нутгийн байгаль хамгаалагчид нь Байгаль орчин, аялал жуулчлалын яам (БОАЖЯ)-нд, сумын байгаль хамгаалагчид нь аймгуудын байгаль орчин, аялал жуулчлалын газруудад, дүүргийн байгаль хамгаалагчид нь нийслэлийн байгаль орчны газарт тус тус харьяалагдах бөгөөд хариуцсан нутаг дэвсгэртээ байгаль орчны бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, сурталчлах, биологийн олон янз байдлын талаар бүртгэл хөтлөх, удирдлагыг мэдээллээр хангах, улсын тусгай хамгаалалттай газрын унаган төлөв байдлыг хадгалан хамгаалах, зэрлэг амьтдын амьдрах таатай орчныг бүрдүүлэх чиг үүргийг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн үр дүнгээ удирдлагын өмнө хариуцан ажилладаг.

БОАЖЯ-наас байгаль хамгаалагчийн чуулга уулзалтыг хийж тэдний нийгмийн болон ажиллах нөхцөл, сурч боловсрох асуудлыг онцгойлон анхаарч байгаль хамгаалагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангахаар ажиллаж байна.

2.2 Хүний нөөцийн удирдлагын SWOT шинжилгээ:

“Монголын байгаль хамгаалагчдийн холбоо” ТББ-аас эрхлэн байгаль хамгаалагчдын дунд, ажилдаа хандах сэтгэл ханамжийг тодорхойлох судалгааг улсын хэмжээнд түүвэр судалгааны аргаар байгаль хамгаалагчаас авсан. Үүнд:

Байгаль хамгаалагчдын ажлын байрны сэтгэл ханамжийн судалгааг авч үзэхэд 68 хувь нь сэтгэл ханамжтай гэсэн үр дүн гарсан. *Одоогийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж үзэхэд* хамгийн өндөр буюу 90.8% нь цалингийн шатлал нэмүүлэх, 85.6% нь хээрийн нэмэгдэл тооцуулдаг болох, 82.8% нь орон нутагт ажилласны урамшуулал олгох, 80.4% нь үүргээ хэвийн гүйцэтгэхэд шаардагдах багаж хэрэгслэл, унаагаар хангах, 78% нь тэтгэврийн насыг наашлуулах санал гаргасан байна.

Мөн одоо ажиллаж байгаа байгаль хамгаалагчдыг шаардлагатай тусгай хэрэгслээр цаашид хангах, байгаль хамгаалагчдын амь нас эрүүл мэнд, гэр бүлийн аюулгүй байдлыг хангах, эрсдэлээс хамгаалах, холбогдох хууль эрх зүйн орчныг бий болгоход анхаарах шаардлага үүссэнийг харуулж байна.

Дээрх судалгааны дүнгээс харахад байгаль хамгаалагчдийн ажил үүрэгтээ хандах хандлагад олон хүчин зүйл нөлөөлдөг боловч дараах хүчин зүйлүүд голлон нөлөөлдөг байна, үүнд:

- Цалин, нэмэгдэл, түүний хэмжээ
- Албан үүргээ гүйцэтгэх явцад үүсэж болзошгүй эрсдэлээс хамгаалах тогтолцоо
- Албан үүргээ хэвийн гүйцэтгэхэд шаардлагатай техник хэрэгслэл, унааны хангамж

Үндсэндээ байгаль хамгаалагчдын ажлын байрны нөхцөлийг бусад ажлын байрнаас тусгайлан авч үзэж анхаарлаа хандуулсан шинэ бодлого боловсруулах шаардлагатай болсон байна.

Байгаль хамгаалагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа нь сэтгэл ханамжид хэрхэн нөлөөлж буйг судалсан дүнгээс харахад:

Хүчин зүйлүүдийн нөлөө	
<p>Ололттой тал:</p> <ul style="list-style-type: none"> - Байгаль хамгаалагчид өөрсдийн ажлаа “эх орноо бүрэн бүтнээр нь хамгаалахад оруулж буй хувь нэмэр” гэж ойлгодог тул сэтгэлээ зориулдаг, - Дадал хандлага нь төлөвшсөн шударга иргэдийн дунд нэр хүндтэй, - ТХГ-ын байгаль хамгаалагчдыг олон улсын төсөл хөтөлбөрөөс дэмжиж зарим нэг багаж хэрэгслэл, дүрэмт хувцас, мотоциклоор хангадаг - Сургалтын хөтөлбөрт мэргэшүүлэх, ур чадварыг нь нэмэгдүүлэхэд чиглэсэн агуулга ямар нэг хэмжээгээр байдаг, 	<p>Анхаарах шаардлагатай тал:</p> <ul style="list-style-type: none"> -Цалин хангамж бага -Байгаль хамгаалагчдын сургалтын тогтолцоо нь цалин хангамж, зэрэг дэв нэмэх хөшүүрэг болж чаддаггүй, -Албан үүргээ гүйцэтгэж байхдаа эрүүл мэнд, сэтгэл санаа, амь насаараа хохирох эрсдэл өндөр, -Эрүүл мэнд, амь насаараа хохирсон тохиолдолд улсаас олгох нөхөн олговор, ямар нэг албан журмын даатгал байхгүй, -Байгаль хамгаалагчдыг эрсдлээс хамгаалсан эрх зүйн орчин сул, -Төв суурин газраас алс ажиллаж байгаа байгаль хамгаалагчдын гэр бүлд ажлын байр байхгүй, хүүхдүүдэд нь сурах нөхцөл, хөнгөлөлт байхгүй, - Төв суурин газраас алс хол байршилд болон ажлын нөхцлөөс шалтгаалан дээд

	<p>боловсролтой байгаль хамгаалагч олддоггүй ба ийм байдлыг Төрийн захиргааны албан хаагчийн шалгалт бүр хүндрүүлдэг, -Хуулийн хэрэгжилтийг хангуулах үүргээ гүйцэтгэхэд нь хууль бус үйл ажиллагаа явуулдаг этгээдүүдтэй хамтран ажиллах сонирхолтой эрх баригчид ажлыг нь, эрх ашгийг нь дэмждэггүй байдал,</p>
--	--

Иймд: Өмнөх үйл ажиллагааны үйл явц, шалгуур үзүүлэлт, дүгнэх арга хэрэгсэл нь тодорхой бус байсныг шинээр боловсруулсан хөтөлбөрт залруулж байгаль хамгаалагчийг тусгайлан оруулж өгч байна.

Гурав. Хөтөлбөрийн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

3.1. Хөтөлбөрийн зорилтууд

1.Байгаль хамгаалагчдын хувь хүний болоод гэр бүлийн хөгжлийг дэмжих, сургалтын хөтөлбөр нь мэдлэг ур чадварыг нэмэгдүүлэхээс гадна цалин хөлс, зэрэг дэв нэмэх хөшүүрэг болгонл,

2.Байгаль хамгаалагчдыг тогтвортой, бүтээмжтэй ажиллуулахын тулд хуулиар олгогдсон эрхийг бүрэн эдлүүлж, эрхийг нь хамгаалан, хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ,

3. Байгаль хамгаалагч нь үүргээ аливаа нөлөөллөөс ангид хэрэгжүүлэх нөхцөлийг эрх зүйн орчныг сайжруулах замаар бүрдүүлэх, амь нас, эрүүл мэндийг эрсдэлээс хамгаалах замаар нийгмийн баталгааг хангана;

3.2. Зорилтуудыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

Зорилт 1. Байгаль хамгаалагчдын хувь хүний болоод гэр бүлийн хөгжлийг дэмжих, сургалтын хөтөлбөр нь мэдлэг ур чадварыг нэмэгдүүлэхээс гадна цалин хөлс, зэрэг дэв нэмэх хөшүүрэг болгоно.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

3.1.1. Байгаль хамгаалагч мэргэжлийг онлайн, эчнээ хэлбэрээр эзэмших боломжийг судлах, хэрэгжүүлэх, боловсон хүчний нөөцийн оновчтой бодлого боловсруулах,

3.1.2. Байгаль хамгаалагчдын сургалтын хөтөлбөрийг шаталсан хэлбэрээр боловсруулах, шаардагдах зардлыг улсын боолон орон нутгийн төсөвт суулгах,

3.1.3. Шаталсан сургалтад хамрагдсаны дараа цалин, зэрэг дэв нэмдэг тогтолцоог бий болгох,

3.1.3. Суурин газраас алсад байршиж амьдардаг байгаль хамгаалагчдын хүүхдүүдийг дунд сургуульд дотуур байраар хангах, дэмжлэг үзүүлэх,

3.1.4. Байгаль хамгаалагчдын мэдлэг, ур чадвар, ажлын үр дүнг 5 жил тутамд үнэлж (аттестатчилж) үр дүнгийн урамшил олгох асуудлыг шийдвэрлэх, холбогдох хууль тогтоомжийг боловсруулж батлуулах,

3.1.5. Байгаль хамгаалагч ур чадвараа нэмэгдүүлэх зорилгоор үүрэгт ажилтайгаа холбоотой сургалтуудад хамрагдахыг хүсвэл төлбөрийн болон бусад дэмжлэг үзүүлэх,

3.1.6. Байгаль хамгаалагчдад авилга, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн сургалтыг тогтмол зохион байгуулах, аливаа шууд болон шууд бус нөлөөллийн хэлбэрийг мэдэгдэх, шийдвэрлэх механизмыг бүрдүүлэх, нөлөөллийн мэдүүлэг гаргадаг жишгийг судлан нэвтрүүлэх.

3.1.7. Тэрбум мод хөтөлбөрийн сургагч хийгээд багшлах ажил давхар эрхлэх боломжийг судлах хэрэгжүүлэх. 1000 сургагч багш бэлтгэхдээ нэн түрүүнд байгаль хамгаалагчдаа хамруулах.

3.1.8. Галт зэвсэгт ашиглах сургалтад хамруулах.

3.1.9. Олон улсын чиг хандлага, орчин үеийн хэрэгцээ шаардлагатай уялдуулан байгаль хамгаалагчдаа хянан шалгагч байхаас гадна зөвлөх, экологийн боловсрол олгох, газарч-тайлбарлагч, мэдлэг түгээгч, ухуулан гэгээрүүлэгчийн чадварыг хөгжүүлэхэд анхаарах.

Зорилт 2. Байгаль хамгаалагчдыг тогтвортой, бүтээмжтэй ажиллуулахын тулд хуулиар олгогдсон эрхийг бүрэн эдлүүлж, эрхийг нь хамгаалан, хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

3.2.1. Байгаль хамгаалагчийг ажлын байр, унаа, бие хамгаалах хэрэгслэл болон ажиглах (дуран, телескоп), бүртгэх (GPS, шаардагдах программ хангамж бүхий зөөврийн компьютер), баримтжуулах (зургийн аппарат, видеокамер, дуу хураагч, автомат камер), холбооны (интернет, богино долгионы болон сансрын утас) багаж, техникээр бүрэн хангах,

3.2.2. Байгаль хамгаалагчийн дүрэмт хувцсыг бусад салбарын хууль сахиулагчдын адил хугацаанд шинэчилж байх,

3.2.3. Байгаль хамгаалагчдыг ажилласан жил, ажлын үр дүн, шаталсан сургалтад хамрагдсан байдал зэргийг харгалзан “туслах”, “жинхэнэ”, “ахлах” зэрэг дэв олгох асуудлыг судалж шийдвэрлэх,

3.2.4. Байгаль хамгаалагчдыг болон тэдний гэр бүлийн хүмүүсийг амь нас, эрүүл мэнд, гэнэтийн ослын даатгалд хамруулах, шаардлагатай зардлыг улсын болон орон нутгийн төсөвт суулгах,

3.2.5. Байгаль хамгаалагчдыг жил бүр нарийн мэргэжлийн үзлэг, шинжилгээнд хамруулах, шаардлагатай зардлыг төсөвт суулгах,

3.2.6. Байгаль хамгаалагчид албан үүргээ гүйцэтгэж байх үедээ эрүүл мэнд, сэтгэл санаагаар хохирсон үед эмчлүүлэхэд гарсан зардлыг төрөөс хариуцах,

3.2.7. Байгаль хамгаалагчдын ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор ажил мэргэжлийн уралдааныг жил бүр зохион байгуулах. Албан үүрэгтэй холбоотой бус, цаг хугацаа, хөдөлмөр, зардал үр дүнгүй зарцуулдаг спорт, урлагийн тэмцээн, уралдааныг үндэсний хэмжээнд зохион байгуулахаас зайлсхийх.

3.2.8. Байгаль хамгаалагчийн ажил, мэргэжлийн онцлог, шилдэг байгаль хамгаалагчдыг сурталчлах.

3.2.9. Байгаль хамгаалагчдын ажлын нөхцлийн “хүнд” эсэхийг холбогдох мэргэжлийн байгууллагаар тогтоолгон дүгнэлт гаргуулах, эрүүл, аюулгүй, ногоон орчинд ажиллаж амьдрах нөхцлийг бүрдүүлэх,

3.2.10. Хариуцан хамгаалах талбайн хэмжээг судалж нормативийг шинэчлэн ажлын ачааллыг жигдрүүлэх.

3.2.11. Байгаль хамгаалагчийн ёс зүйн дүрмийг орчин үеийн байгаль хамгааллын нийтлэг зарчим, үнэт зүйлс, хэм хэмжээ, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж, мөрдөх. (Дэлхийн байгаль хамгаалагчдын ёс зүйн дүрмийг ашиглах)

3.2.12. Байгаль хамгаалагчдын ажлын байр, албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулах

3.2.13. “Төрийн албаны тухай” хуулийн “61.1.4”, дахь заалтын хэрхэн хэрэгжүүлж байгаа талаар орон нутгийн байгаль хамгаалагч ажиллуулдаг байгууллагуудад үнэлгээ өгөх,

Зорилт 3. Байгаль хамгаалагч нь үүргээ аливаа нөлөөллөөс ангид хэрэгжүүлэх нөхцөлийг эрх зүйн орчныг сайжруулах замаар бүрдүүлэх, амь нас, эрүүл мэндийг эрсдэлээс хамгаалах замаар нийгмийн баталгааг хангана;

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

3.3.1. Байгаль хамгаалагч албан үүргээ гүйцэтгэх явцдаа сүрдүүлэг, заналхийлэл болон халдлагад өртсөн тохиолдолд “Хууль сахиулагч”-д халдсан гэж үзэж хуулийн дагуу эрүүгийн хуулийн дагуу хатуу хариуцлага хүлээлгэдэг байх,

3.3.2. Албан үүргээ гүйцэтгэхтэй нь холбоотой хүчирхийлэх, заналхийлэх, доромжлох, гүтгэх болон бусад хууль бус үйлдэл, үйл ажиллагаанаас байгаль хамгаалагч, түүний гэр бүлийн гишүүдийн аюулгүй байдлыг хангах ажлыг тухайн байгууллагын удирдлага зохион байгуулах, эрх зүйн туслалцаа үзүүлэх,

3.3.3. Байгаль хамгаалагчийн эрх, үүрэгтэй холбоотой хууль тогтоомжуудад үнэлгээ хийх,

3.3.4. “Байгаль хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай” хуулийн төсөл боловсруулах, хэлэлцүүлэг хийх, өргөн барих,

3.3.5. Байгаль хамгаалагчдын ажиллах нөхцлийг “хүнд” зэрэглэлд оруулах асуудлыг судлан шийдвэрлэх,

3.3.6. Байгаль хамгаалагчаар 25 жил ажилласан болон, 55 нас хүрсэн бол тэтгэвэр тогтоолгох боломжийг судлах, шийдвэрлэх,

3.3.7. Байгаль хамгаалагчдын эрсдлийн сан бий болгох,

3.3.8. Халдлага, дарамтад орсон, эрүүл мэнд, сэтгэл санаа, амь насаараа хохирсон байгаль хамгаалагчдын бүртгэлийг бий болгон мэдээллийн санд хадгалах асуудлыг журамлах,

3.3.9. Байгаль хамгаалагчдыг хөнгөлөлттэй нөхцлөөр орон сууцаар хангах, түлшээр хангах, буцалтгүй тусламж үзүүлэх нөхцөлийг судлан шийдвэрлэх.

3.3.10. Байгаль хамгаалагчдын ажлын үр дүн, ёс зүйн хэм хэмжээ, ур чадвар, үүрэгт ажилдаа шударга, нөлөөлөд авталгүй ажилласан байдал зэргийг харгалзан байгууллага, төрийн дээд цол, одон медалиар шагнуулах,

3.3.11. Улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай гзарын байгаль хамгаалагчдыг “Төрийн үйлчилгэний”, аймгийн байгаль орчин аялал жуулчлалын газар, сумын ЗДТГ-ын харъяаллын байгаль хамгаалагчдыг “Төрийн захиргааны” ангилалд хамруулах асуудлыг судлан шийдвэрлүүлэх,

3.3.12. Улс төрийн үзэл бодлоор нь ялгаварлах, шударга шаардлагад эмзэглэх зэргээр байгаль хамгаалагчийн хөдөлмөрлөх эрхийг зөрчсөн үйлдэл, хандлага гаргахаас сэргийлэх, эмэгтэй байгаль хамгаалагчдын хувьд жендерийн ялгаварлан гадуурхалт бүхий үг хэллэг, үйлдэл гаргаж, сэтгэл санааны дарамт учруулсан зүй бус үйлдлүүдийг үл тэвчиж, ийм үйлдэлд хариуцлага хүлээлгэдэг, олон нийтэд мэдээлдэг байх.

3.3.13. Байгаль хамгаалагчдад ажлын гүйцэтгэл, үр дүн, хөдөлмөрийн бүтээмжтэй уялдсан урамшуулал олгох. Хураалгасан байгалийн баялгийн борлуулалтын орлогын 15 хувийг тухайн зөрчлийг илрүүлсэн байгаль хамгаалагчид тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос олгох хуулийн заалтын хэрэгжилтийг хангуулах.

3.3.14. Байгаль хамгаалагчийн ажлыг гэр бүлээрээ хийдэг. Хүссэн хүсээгүй тэдний гэр бүл байгаль хамгаалагчид болдог. Иймд гэр бүлийн хөгжлийг дэмжих шаардлагаар төрийн албан хаагчид хууль тогтоомжоор хориглоогүй, гэр бүлээрээ хийх боломжтой аж ахуйд дэмжлэг үзүүлэх, амьжиргааг дэмжих бусад салбарын төсөл, хөтөлбөрүүдэд хамруулах, зээлийн баталгаа гаргах, гэр бүлийн хүмүүсийн ажил эрхлэлтийг гадаадын болон олон улсын байгууллагуудаас хамтран хэрэгжүүлж буй төслүүдэд бодлогоор зорилт болгон оруулах зэргээр дэмжих.

3.3.15. Улсын байцаагчийн эрх бүхий байгаль хамгаалагчийн цалинг ТЗ-6-аар тооцож шууд олгодог тогтолцоонд шилжих,

Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэр

4.1. Хөтөлбөрийг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

4.1.1. улс, орон нутгийн төсөв

4.1.2. гадаадын болон олон улсын байгууллагын төслийн дэмжлэг, буцалтгүй тусламж

4.1.3. төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн тусламж, хандив,

4.1.4. хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэр.

Тав. Хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнг үнэлэх

5.1.1. Улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газрын байгаль хамгаалагчидтай холбоотой асуудлыг тухайн тусгай хамгаалалттай газрын менежментийн төлөвлөгөөнд тусгах замаар хөтөлбөрийн хэрэгжилтийг хангана.

5.1.2. Орон нутгийн харъяаллын байгаль хамгаалагчидтай холбоотой асуудлыг тухайн байгууллагууд жилийн төлөвлөгөөндөө нарийвчлан тусгаж хэрэгжүүлнэ.

5.1.3. Байгаль орчин аялал жуулчлалын сайд аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулах гэрээндээ тусгах замаар энэхүү хөтөлбөрийн орон нутгийн байгаль хамгаалагчидтай холбоотой заалтуудын хэрэгжилтийг хангах ба хянана.

5.4. Хөтөлбөрийн хэрэгжилтийг БОАЖЯ-ны УТХБН-ийн удирдлагын газар, Төрийн захиргаа удирдлагын газар, хяналт үнэлгээ- дотоод аудитын газрууд “Монголын байгаль хамгаалагчдын холбоо” ТББ-тай хамтран дүгнэнэ.

5.5. Шаардлагатай бол хөндлөнгийн үнэлгээг мэргэшсэн төрийн бус байгууллагаар хийлгүүлж болно.

5.6. Хэрэгжилтийн үр дүнг БОАЖ-ын сайдын зөвлөлд төрийн захиргаа, удирдлагын газар хариуцан хэлэлцүүлнэ.

5.7. Хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг дараа оны 1 дүгээр сард багтаан Төрийн албаны зөвлөл, хууль зүй дотоод хэргийн яам, холбогдох газруудад хүргүүлнэ.

---oOo---

VII.10. Байгаль хамгаалагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр



МОНГОЛ УЛСЫН БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙДЫН ТУШААЛ

2022 оны 10 сарын 25 өдөр

Дугаар 21451

Улаанбаатар хот


Байгаль хамгаалагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3 дахь хэсэг, Төрийн албаны зөвлөлийн Байгаль орчин, аялал жуулчлалын яамны дэргэдэх салбар зөвлөлийн 2022 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн хуралдааны 3 дугаар тэмдэглэл, 26 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Байгаль хамгаалагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг байгууллагын жил бүрийн төсөвт тусгаж, тухайн жилд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг жил бүрийн нэгдүгээр улиралд боловсруулан батлуулж, зохион байгуулалт, удирдлагаар хангаж, үр дүнг тайлагнаж ажиллахыг аймаг, нийслэлийн байгаль орчны газар, улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн Байгаль орчин, аялал жуулчлалын яамны дэргэдэх салбар зөвлөл (Э.Баттулга)-д даалгасугай.

САЙД  Б.БАТ-ЭРДЭНЭ

152211203

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын
2022 оны 10 дугаар сарын 25 өдрийн
А/А дугаар тушаалын хавсралт

БАЙГАЛЬ ХАМГААЛАГЧДЫН АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААНЫ ХӨТӨЛБӨР

Нэг. Хөтөлбөрийн зорилго

1.1.Байгаль хамгаалагчдын хэрэгцээг бодитоор тодорхойлж, хөтөлбөр хэрэгжүүлэх замаар ажиллах нөхцөлийг сайжруулж, нийгмийн баталгааг нь хангах зорилготой.

Хоёр. Хөтөлбөр хэрэгжүүлэх зарчим, хугацаа

2.1.Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална:

- 2.1.1.Байгаль хамгаалагч нэг бүрийг хамруулах;
- 2.1.2.Ил тод, нээлттэй хэрэгжүүлэх;
- 2.1.3.Бодитой, үр дүнтэй байх;
- 2.1.4.Нөөц бололцоог бүрэн дайчлах;
- 2.1.5.Бүтээлчээр хандах.
- 2.2.Хөтөлбөрийг 5 жилийн хугацаатай хэрэгжүүлнэ.

Гурав. Хөтөлбөрийн зорилт

3.1.Хөтөлбөрийг дараах зорилтын хүрээнд хэрэгжүүлнэ.

- 3.1.1.Төрийн албан хаагчид хуулиар олгогдсон эрхийг бүрэн эдлүүлж, нийгмийн баталгааг хангах;
- 3.1.2.Байгаль хамгаалагчдын хувь хүний болоод гэр бүлийн хөгжлийг дэмжих, эрүүл мэндийг хамгаалах замаар тогтвортой, бүтээмжтэй ажиллуулах;
- 3.1.3.Ажил үүргээ аливаа нөлөөллөөс ангид хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх.

Дөрөв. Хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээ

4.1.Төрийн албан хаагчид хуулиар олгогдсон эрхийг бүрэн эдлүүлж, нийгмийн баталгааг хангах хүрээнд:

- 4.1.1.Байгаль хамгаалагчдыг гэнэтийн ослын даатгалд хамруулах, хууль зөрчигчдийн зүгээс ирж болзошгүй аливаа хавчлага, дарамтыг бууруулах, энэ чиглэлээрх сайн туршлагыг нэвтрүүлэх;
- 4.1.2.Төрийн захиргааны албан хаагч алслагдсан бүс, орон нутагт байгаль хамгаалагчаар ажиллахад орон нутгийн нэмэгдлийг 20 хувиар олгох;
- 4.1.3.Байгаль хамгаалагчид ажлын гүйцэтгэл, үр дүн, хөдөлмөрийн бүтээмжтэй уялдсан урамшуулал олгох, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг жил тутам тооцон олгох нөхцөлийг Төсвийн шинэчлэлийн бодлоготой уялдуулан бүрдүүлэх;
- 4.1.4.Байгаль хамгаалагчдыг төрийн албаны тухай хууль тогтоомжийн хүрээнд ажил сайжруулах, сайн туршлага нутагшуулах зорилгоор шилжүүлэн болон сэлгэн ажиллуулах;
- 4.1.5.Үйл ажиллагааны үр дүнг харгалзан гадаад улсын байгаль хамгаалагчидтай туршлага солилцох солилцооны хөтөлбөр, богино, дунд хугацааны сургалт, дадлагад хамруулах;

4.1.6.Шинээр томилогдсон байгаль хамгаалагчдад зориулсан чиглүүлэх сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж, гарын авлага, цогц мэдээллээр хангах, мотоцикл унах, галт зэвсэг ашиглах сургалтад тухай бүр хамруулах;

4.1.7.Албан үүргээ гүйцэтгэж байгаатай нь холбогдуулан хүчирхийлэх, заналхийлэх, гүтгэх, доромжлох болон бусад хууль бус үйлдэл, үйл ажиллагаанаас байгаль хамгаалагчдыг болон гэр бүлийг нь хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг байгууллагын удирдлага тухай бүр авч хэрэгжүүлж хэвших;

4.1.8.Олон улсын нийтлэг жишгийн дагуу байгаль хамгааллын ажилд технологийн дэвшлийг түлхүү ашиглаж, байгаль хамгаалагчдыг иргэдэд экологийн боловсрол олгох, уламжлалт мэдлэг түгээх, нутаг орноо сурталчлах, иргэдийг байгаль хамгаалах чиглэлд түлхүү ажиллуулах, энэ чиглэлээр албан тушаалын тодорхойлолтод өөрчлөлт оруулах;

4.1.9.Байгаль хамгаалагчдын ажлын байрны ашиглалтыг сайжруулж, иргэд, олон нийт тухайн нутаг дэвсгэрийн талаар цогц мэдээлэл авах орчныг бүрдүүлэх.

4.2.Байгаль хамгаалагчдын хувь хүний болоод гэр бүлийн хөгжлийг дэмжих, эрүүл мэндийг хамгаалах замаар тогтвортой, бүтээмжтэй ажиллуулах зорилтын хүрээнд:

4.2.1.Байгаль хамгаалагчдын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, эрүүл хооллолт, эрүүл амьдралын хэвшилд сургах цуврал сургалтыг зохион байгуулах;

4.2.2.Байгаль хамгаалагчдыг жилд нэг удаа урьдчилан сэргийлэх эрүүл мэндийн үзлэгт хамруулах;

4.2.3.Байгаль хамгаалагчдын хүүхдийн сурч боловсрох эрхийг хангах, ажлын байрны ойр байршилтай цэцэрлэг, сургууль, дотуур байранд хамруулах, зуны амралтаар нь хүүхдийн зусланд явуулах зэрэг асуудлаар орон нутгийн захиргаадтай хамтран ажиллах;

4.2.4.Байгаль хамгаалагчдын ажил амьдралын тэнцвэрийг хадгалах, гэр бүлийн хариуцлагатай гишүүн байхад нь боломжит дэмжлэгийг үзүүлэх;

4.2.5.Байгаль хамгаалагчдын дунд нийгэм, соёл, спортын олон талт арга хэмжээ, ажил мэргэжлийн уралдааныг зохион байгуулж хэвших;

4.2.6.Байгаль хамгаалагчдын ажлын байрыг байгальд ээлтэй, ногоон барилгын шаардлагад нийцүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлэх;

4.2.7.Байгаль хамгаалагчдын хариуцан хамгаалах талбайн нормативыг байгаль газар зүйн нөхцөл, нөөц, нийгмийн хүчин зүйлсийг харгалзан ялгавартай тогтоох, шинэчлэх;

4.2.8.Мод, жимс, ногоо тарих, зөгий үржүүлэх зэрэг төрийн албан хаагчид хууль тогтоомжоор хориглоогүй, гэр бүлээрээ хийх боломжтой аж ахуйд дэмжлэг үзүүлэх, амьжиргааг дэмжих бусад салбарын төсөл, хөтөлбөрүүдэд хамруулах, зээлийн баталгаа гаргах, гэр бүлийн гишүүний ажил эрхлэлтийг дэмжих;

4.2.9.Байгаль хамгаалагчдыг судалгааны арга зүйд сургаж, судалгаа шинжилгээний байгууллагуудын анхан шатны мэдээлэл цуглуулах, ажиглалтын ажилд татан оролцуулах;

4.2.10.Байгаль хамгаалагчдыг мэргэжил, мэдээллийн технологи, хувь хүний хөгжлийн чиглэлээр чадавхжуулах, давтан сургах сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө баталж, хэрэгжүүлэх ажлыг танхимаар болон зайнаас үр дүнтэй зохион байгуулах, хичээлийг нөхөж үзэх боломжтой байдлаар сургалтын платформыг хөгжүүлж, нэвтрүүлэх;

4.2.11.Ажиглалт, орчны хяналт шинжилгээг олон улсад түгээмэл ашиглагддаг систем, төхөөрөмж ашиглан хийдэг болох;

4.2.12.Идэвхтэн байгаль хамгаалагчийн эрхийг болзол, шаардлага хангасан иргэдэд чирэгдэлгүй олгож, байгаль хамгаалах ажилд олон нийтийн оролцоог хангах.

4.3.Байгаль хамгаалагч ажил үүргээ аливаа нөлөөллөөс ангид хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилтын хүрээнд:

4.3.1.Хуульд заасан шалгуур, шаардлагыг хангасан байгаль хамгаалагчдад улсын байцаагчийн эрх олгох;

4.3.2.Байгаль хамгаалагчдад авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн сургалтыг тогтмол зохион байгуулах, аливаа шууд болон шууд бус нөлөөллийн хэлбэрийг мэдэгдэх, шийдвэрлэх механизмыг бүрдүүлэх;

4.3.3.Байгаль хамгаалагчдыг Монгол орны байгалийн нөхцөлд тохирсон ялгах тэмдэг бүхий ээлжийн хувцас, орчин үеийн дэвшилтэт тоног төхөөрөмж, техник, хамгаалах хэрэгслээр нэг бүрчлэн хангах, байгаль хамгаалагчийн хамгаалах хэрэгслийн жагсаалтыг гаргаж батлуулах

4.3.4.Байгаль хамгаалагчийн ёс зүйн дүрмийг орчин үеийн байгаль хамгааллын нийтлэг зарчим, үнэт зүйлс, хэм хэмжээ, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж, мөрдөх;

4.3.5.Иргэдэд чиглэсэн байгаль хамгаалагчийн ажил, мэргэжлийн онцлогийн талаарх ухуулга, сурталчилгааны аян өрнүүлэх;

4.3.6.Эмэгтэй байгаль хамгаалагчдыг жөндөрийн ялгаварлан гадуурхалт бүхий орчинд ажиллуулахыг үл тэвчиж, дарамт учруулсан зүй бус үйлдэлд тухай бүр хариуцлага тооцдог байх.

Тав. Хөтөлбөрийн хүрэх үр дүн, санхүүжилт

5.1.Энэ хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрэхээр төлөвлөж байна. Үүнд:

- Байгаль хамгаалагчид хууль тогтоомжид заасан нийгмийн баталгаагаа хүртэж, төрийн албаны үйл ажиллагаа тасралтгүй, тогтвортой байх зарчим хангагдана;

- Хүний нөөцийн хувьд чадварлаг, ажлын дадлага туршлагатай, мэргэшсэн хамт олон бүрдэнэ;

- Байгаль хамгаалагчдын хувь хүний хөгжил, мэргэшлийн ур чадвар, бүтээмж дээшилнэ;

- Байгаль хамгаалагчид, тэдний гэр бүлийн оролцоонд суурилсан арга хэмжээг тогтмол хэрэгжүүлэх замаар төрийн албаны ёс зүйг баримталсан, хууль дээдэлсэн, эрүүл уур амьсгал, харилцааны эерэг хандлагыг төлөвшүүлнэ;

- Албан тушаалын чиг үүргээ аливаа нөлөөллөөс ангид хэрэгжүүлэх нөхцөл, боломж бүрдэнэ;

- Байгаль хамгаалагчаар ажиллах сонирхолтой иргэдийн тоо нэмэгдэнэ.

5.2.Хөтөлбөрийг улсын, орон нутгийн төсөв, хуулиар хориглоогүй бусад эх үүсвэрээр санхүүжүүлнэ.

Зургаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх, үнэлэх


6.1.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх жилийн төлөвлөгөөг яамны төрийн захиргааны асуудал хариуцсан нэгж, тусгай хамгаалалттай бүс нутгийн асуудал хариуцсан нэгж хамтран боловсруулж, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн даргаар батлуулан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

6.2.Улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа, нутгийн захиргааны байгууллагууд өөрийн онцлог, нөхцөл боломжид нийцүүлэн дэд төлөвлөгөөг батлан хэрэгжүүлнэ.

6.3.Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын асуудал хариуцсан нэгж хөтөлбөрийн хэрэгжилтэд жил бүр хяналт- шинжилгээ, үнэлгээ хийж, гүйцэтгэлийг дүгнэн байгаль хамгаалагчид болон яамны удирдлагуудад танилцуулна.

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ

VII.11. Даалгаварт ажлын хамрах хүрээ



“Монголын байгаль хамгаалагчдын холбоо” ТББ

С.Амгаланбаатар